



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP

# МОНГОЛ ХЭЛ III

## ГАРЫН АВЛАГА



Улаанбаатар хот  
2023 он



А.ЕРКЕГҮЛ, Ц.БАЯСГАЛАН, М.ХАРШЫГА, Д.РАЯ

# МОНГОЛ ХЭЛ III

## ГАРЫН АВЛАГА

Хос хэлний сургалттай ерөнхий боловсролын  
сургуулийн 3 дугаар ангид судална.

Улаанбаатар хот  
2023 он

ННА 74.1  
ДДА 372  
М-692

Монгол хэл III: Хос хэлний сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар  
ангийн гарын авлага. /УБ.2023, 96 нүүр/

Энэхүү гарын авлагыг Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Дэлхийн Банкны  
хамтран хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн дэмжлэгээр  
боловсруулж, хэвлэв.

© Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн

ISBN: 978-9919-9004-2-7

## Гарчиг

Сэргээн санах	4-8
Бүлэг I: Би	9-20
Бүлэг II: Гэр бүл	21-30
Бүлэг III: Сургууль	31-40
Бүлэг IV: Ажил хөдөлмөр	41-48
Бүлэг V: Хүрээлэн буй орчин харилцаа холбоо	49-56
Бүлэг VI: Эрүүл амьдрал	57-66
Бүлэг VII: Амьтад	67-74
Бүлэг VIII: Байгаль дэлхий	75-80
Бүлэг IX: Хувцаслалт, хувийн соёл	81-86
Бүлэг X: Уламжлалт ёс заншил, тэмдэглэлт баяр ёслол	87-92
Бататгал:	93-96

## Таних тэмдэг



Сонсоорой



Нэрлээрэй



Уншаарай



Зохиогоорой



Яриарай



Цээжлээрэй



Бичээрэй



Тайлбарлах



Хариулаарай



Бүтээгээрэй

СЭРГЭЭН САНАХ



1. Шүлгийг уран тод уншаарай. Цээжлээрэй.

**Дэлгэр зун**  
(шүлэг)

Цагийн сайхан зуны эхэнд  
Газрын сайхан Хангайн нуруунд  
Хөхөө шувуу урьхнаар донгодоход  
Энэхүү дэлхий юутай тааламжтай

*Д.Нацагдорж*



*Хангайн нуруу*




2. Асуултад хариулаарай.

- А. Ямар улирлын тухай бичсэн шүлэг байна вэ?
- Б. Шүлгийг хэн бичсэн бэ?
- В. Зун цаг яагаад сайхан байдаг вэ?
- Г. Зуны дараа ямар улирал болдог вэ?



3. Өгүүлбэр болгон уншаарай. Дэвтэртээ бичээрэй.



4. Хүүхдүүдэд нэр өгч, өгүүлбэр зохиогоорой.





Амар ..... сайхан амрав. ....,  
 ..... хоёр бөмбөг тоглов.  
 ..... дээс тоглож байна.  
 ....., ..... нар хамт тоглов.

 1. Цагаан толгойн үсгүүдээ зөв, тод хэлээрэй.


**БҮХ ҮСЭГ - 35**

Аа	Бб	Вв	Гг	Дд	Ее	Ёё
Жж	Зз	Ии	Йй	Кк	Лл	Мм
Нн	Оо	Өө	Пп	Рр	Сс	Тт
Уу	Үү	Фф	Хх	Цц	Чч	Шш
Щщ	Ъъ	Ыы	Ьь	Ээ	Юю	Яя




 2. Цагаан толгойн үсгийн ангиллын тоог бичээрэй.


Бүх үсэг	<input type="text"/>	Гийгүүлэгч үсэг	<input type="text"/>
Эгшиг үсэг	<input type="text"/>	Тэмдэг үсэг	<input type="text"/>

 3. Цагаан толгойн үсгийг ангилж бичээрэй.

- А. Эгшиг үсэг: .....
- Б. Гийгүүлэгч үсэг: .....
- В. Тэмдэг үсэг: .....

 4. Богино, урт, хос эгшигтэй үгсийг зөв дуудан уншаарай.

аав, авлаа, орох, тарав, унших, давтах, зун, намар, хавар, багш, даалгавар, ажил  
 ээж, эгч, ирлээ, өгөв, бичсэн, үзэх, хичээл, үзэг, ирж, үзэг, хэл, идэх, хэлэх, үз  
 байна, сайн, ой, хүйтэн, байх, найз, оймс, айх, сайхан, тайван, айл, ой мод

 5. Дээрх үгсийг бүлэглэн бичээрэй.



## ДАСГАЛ 3



1. Эхийг уншиж гарчиг өгөөрэй. Тодруулсан үгсийг давтан уншаарай.

.....

**Миний** нэр Анужин. Би **найман настай**. Миний **өвөө, эмээ хөдөө амьдардаг**. Би зуны **амралтаараа** аав, ээж, ах, эгчийн хамт **өвөөгийнд** очиж амарсан. **Өвөөгийнх** олон малтай.



2. Асуултад хариулж бичээрэй.

- А. Анужин хэдэн настай вэ?
- Б. Анужин зуны амралтаараа хаана очиж амарсан бэ?
- В. Тэр өвөөгийндөө хэн, хэнтэй очсон бэ?
- Г. Өвөөгийнх хэчнээн малтай вэ?



3. Зураг дээр юу, юу байгааг нэрлээд, өгүүлбэр зохиогоорой.



4. Зохиосон өгүүлбэрээ дэвтэртээ алдаагүй бичиж, бусдад уншиж өгөөрэй.

Жишээ нь: Би морь унах дуртай. Хонь, ямааг бог мал гэдэг.



5. Өгүүлбэрийг уншаад, бичээрэй.

Энэ манай аавын



Ээж



саав.




том амьтан.


Манай аймагт




олон.

 1. Хувцсыг нэрлээд, өгүүлбэр зохиогоорой.




 2. Дээрх хувцсыг өнгөөр нь бүлэглэн бичээрэй.

улаан	цамц,
хөх	
цагаан	
ягаан	
ногоон	

 3. Өгүүлбэрүүдийг зөв дараалалд оруулан дэвтэртээ бичээрэй.



 4. Шинж чанарыг нэрлэсэн үгсийг уншаарай.

хурдан морь  
цоохор ишиг  
хүрэн бух  
хөөрхөн тугал  
бор хурга

том сандал  
өндөр ширээ  
нарийн зам  
урт гудамж  
зузаан дэвтэр

халуун цай  
гашуун тараг  
амтат талх  
өтгөн сүү  
шаржигнуур тахиа

## ДАСГАЛ 5

1. Зурагт эхийг уншаад, дэвтэртээ бичээрэй.



бол хүнсний ногоо.



бол жимс.



ба



эрүүл мэндэд ашигтай.

2. Хүнсний ногоо ба жимсний нэрсийг зөв уншиж, бичээрэй.

### Хүнсний ногоо

лууван  
төмс  
байцай  
манжин  
чинжүү  
хүрэн манжин  
сонгино  
сармис

### Жимс жимсгэнэ

алим  
лийр  
усан үзэм  
гадил  
шийгуа  
жүрж  
чавга  
хан боргоцой

3. Зургийн дагуу ярилцаарай.



Намар

- А. Зурагт ямар улирлыг харуулсан байна вэ?
- Б. Мод, ургамал ямар өнгөтэй байна вэ?
- В. Амьтад юу хийж байна вэ?
- Г. Чи намрын улиралд ямар хувцас өмсдөг вэ?
- Д. Навчны өнгийг ажигласан уу?
- Е. Яагаад өнгө нь өөрчлөгддөг вэ?

## Бүлэг I. БИ

### Зурагт толь



тэмдэглэлийн  
дэвтэр



гулгах




хөөх



түүх



цана



чарга



тэшүүр




дуу дуулах



шатар тоглох



бай онох



хээр хонох



занах



санах



баг



баг



сонирхох



мянга



арван мянга



зуун мянга



нэг сая

## ДАСГАЛ 1



1. Харилцан яриаг зөв уншаарай.



- Сайхан амарсан уу?  
- Өглөөний мэнд!

- Өдрийн мэнд, багш аа  
- Өдрийн мэнд, хүүхдүүд ээ!



- Оройн мэнд, ах аа!  
- Оройн мэнд, миний дүү!



- Тавтай нойрсоорой.  
- Сайхан амраарай.



2. Зөв унших, ярих дасгал хийгээрэй. Цэвэр сайхан бичээрэй.

Өглөөний мэнд  
Өдрийн мэнд  
Оройн мэнд

Сайхан амарсан уу?  
Сайхан амраарай  
Тавтай нойрсоорой

1. Харилцан яриаг уншаарай.

1. Сайн уу? Чамайг хэн гэдэг вэ?

2. Сайн. Намайг Болор гэдэг.

3. Чамайг хэн гэдэг вэ?

4. Намайг Амар гэдэг.

5. Чамд монгол хэлний ном байна уу?

6. Надад монгол хэлний ном байгаа.

2. Эдгээр үгсийг зөв, хурдан уншаарай.

би

надад      намайг

чи

чамд      чамайг

3. Өгүүлбэрийг гүйцээн хичээнгүй сайхан бичээрэй.

Би  
Миний  
Надад ..... дуулах дуртай.  
Намайг ..... цүнх мөн.  
..... өгөөрэй.  
..... хараарай.

Чи  
Чиний  
Чамд ..... хэдэн настай вэ?  
Чамайг ..... ном мөн үү?  
..... баярлалаа.  
..... дуудаж байна.



1. Харилцан яриаг ойлгож уншаарай.



Сайн байна уу?

Миний нэрийг  
Амар гэдэг.

Сайн. Сайн байна уу?



Чиний нэрийг  
хэн гэдэг вэ?



Харин чамайг хэн гэдэг вэ?

Чи аль сургуульд,  
хэддүгээр ангид  
сурдаг вэ?

Намайг Саруул гэдэг.

Би Алтай сумын ерөнхий  
боловсролын нэгдүгээр  
сургуулийн гуравдугаар  
ангид сурдаг.



Найз аа. Чи хаана  
сурдаг вэ?



Би Өлгий сумын ерөнхий боловсролын  
гуравдугаар сургуулийн гуравдугаар  
ангид сурдаг. Би чөлөөт цагаараа  
төрөл бүрийн дугуйланд явдаг. Англи  
хэл сайн сурч байгаа.

Би шатрын дугуйланд  
явдаг.



Чи дугуйланд явдаг уу?

Би ирээдүйд  
нисгэгч болохыг  
хүсдэг.

Монгол хэл, англи хэлийг  
сайн сурах хүсэлтэй.  
Ном их уншдаг.



Харин чиний хүсэл юу вэ?





2. Асуултад тохирох өгүүлбэрүүдийг ялгаж уншаарай.

- А. Саруул хэддүгээр ангид сурдаг вэ?
- Б. Англи хэлийг хэн сайн сурч байна вэ?
- В. Хэн шатрын дугуйланд явдаг вэ?
- Г. Хэн ирээдүйд нисгэгч болохыг хүсдэг вэ?



3. Хэдэн өгүүлбэр бүтээж болох вэ? Бичээрэй.



4. Үгсийг зөв байрлуулан өгүүлбэр зохиогоорой.

болов.

найзууд

Амар

Саруул

сайн

хоёр



5. Дараах үгсийг харьцуулж зөв дуудан уншаарай.  
Н үгсийн бичлэгийг ажиглаарай.

“Н” үсэг ардаа  
эгшиггүй бол хэлний  
үгийн “н” гэнэ.

сан  
он  
хан  
тун  
эн  
хон  
зан

сана  
оно  
хана  
туна  
тэнэ  
хоно  
зана

“Н” үсэг ардаа  
эгшигтэй бол хэлний  
үзүүрийн “н” гэнэ.



6. Тохирох үгийг нөхөж бичээрэй.

2022 .....болж байна. (он, оно)

Хүний ..... олон янз. (зана, зан)

Номын ..... оров. (сан, сана)

Хээр талд ..... (хон, хоно)



1. Товч танилцуулга бөглөх загвартай танилцаарай.

Товч танилцуулга бөглөх загвар

1. Овог: Саруул нэр: Амар
2. Төрсөн он: 2015 он 01 сарын 20 өдөр
3. Регистрийн дугаар: БЮ13212021
4. Нас: 8
5. Хүйс: эм
6. Гэрийн хаяг: Баян-Өлгий аймаг, Толбо сум, 2 дугаар баг
7. Холбоо барих утас: аав: 98558844  
ээж: 88427456  
өөрийн: 99426785
8. Сургуулийн хаяг: Толбо сумын ерөнхий боловсролын сургууль



2. Түлхүүр үгийг ашиглан өөрийн танилцуулгыг бүтээгээрэй.

Миний танилцуулга

чөлөөт цаг 5

сурдаг 4

амьдардаг 3

нас, хүйс 2

овог, нэр 1



3. Зөв уншаарай.

Хоёр мянга хорин гурван он  
 Хоёрдугаар сарын хорин гуравны өдөр  
 Ерэн найм, тавин тав, наян гурав, жаран тав  
 Наян найм, дөчин хоёр, далан долоо, хорин зургаа  
 Ерэн ес, дөчин хоёр, хорин нэг, ерэн дөрөв



4. Дээрх үгсийг тоогоор бичээрэй.



5. Өөрийнхөө мэдэх утасны дугааруудаас тавыг үгээр болон тоогоор бичээд, зөв уншаарай.

## ДАСГАЛ 6



1. Шүлгийг цээжлээрэй. Уран тод уншаарай.

### Амин хүү дээ би

Аав ээжийн  
Амин хүү дээ би  
Алт мөнгөнөөс  
Үнэтэй хүү дээ би

Ах эгчийн  
Алиман дүү дээ би  
Азын шоо шиг  
Мундаг хүү дээ би

Эмээ өвөөгийн  
Эрх хүү дээ би  
Өвөр дээр нь  
Өссөн хүү дээ би



2. Дараах үгсийн утгыг багштайгаа хамтран тайлбарлаарай.



3. Шүлгээс цэгийн оронд тохирох үгийг олж нөхөж бичээрэй.

Аав ээжийн амин .....

..... алиман дүү дээ би

Эмээ, өвөөгийн .....



4. Шүлгээс эр, эм, саармаг эгшигтэй үгийг хүснэгтэд ялгаж бичээрэй.

- а, о, у - эгшиг орсон үг **эр үг** болно.
- э, ө, ү - эгшиг орсон үг **эм үг** болно.
- и - саармаг эгшиг
- и - эгшиг орсон үг **эм үг** болно.


Эр эгшигтэй үг	Эм эгшигтэй үг	Саармаг эгшигтэй үг

эр  
эгшигтэй  
үг

ав  
аав  
олон  
уул


эм  
эгшигтэй  
үг

эм  
ээж, би  
өд, бид  
үүл, ишиг

 1. Эхийг уншаарай.

Найзуудын мөрөөдөл


**Билгүүн, Аюуш, Заяа** гурав найзууд. Тэд гуравдугаар **ангид** сурдаг. **Билгүүн зураг сайн** зурдаг. Ирээдүйд **зураач** болохыг хүсдэг. Аюуш **бүжиглэх** дуртай. Тэр ээж **шигээ бүжигчин** болохыг мөрөөддөг. Заяагийн аав барилгачин. Тэр ирээдүйд аавтайгаа адилхан **барилгачин болно** гэж ярьдаг.

 2. Дарааллын дагуу уншаарай.

1, 2 дугаар өгүүлбэр

3, 4 дүгээр өгүүлбэр

5, 6 дугаар өгүүлбэр

 3. Асуултын дагуу өгүүлбэр бүтээн уншаарай.


Хэн?

юу?


яахыг?

яадаг?



 4. Хэн ямар мэргэжилтэй болохыг хүсдэг вэ? Хичээнгүй сайхан бичээрэй.

Билгүүн .....  
Аюуш .....  
Заяа .....


 5. Мөрөөдлөө бичээрэй.

Миний мөрөөдөл

.....  
.....  
.....

## ДАСГАЛ 8

1. Зургийн дагуу өөрийн болон найзынхаа, дүүгийнхээ хүсэл мөрөөдлийг яриарай.



2. Тохирох үгийг олоод өгүүлбэрийг гүйцээн хэлээрэй.

3. Хичээнгүй сайхан бичээрэй. (хүсдэг, мөрөөддөг, сонирхдог)

Би ирээдүйд багш болохыг .....

Миний найз том болоод Япон улсад аялахыг .....

Туяа байгалийн зургийг .....

4. Тоглоом тоглоё. Зургаас аль нэг мэргэжлийг сонгож, тэр мэргэжлийн талаар өөрийнхөө мэдэх зүйлийг яриарай.

Жишээ нь: Тогооч цагаан хувцастай, амттай хоол хийдэг гэх мэт







1. “Дөрвөн хүсэл” эхээс доорх асуултад хариулах үгсийг түүж бичээрэй.

Хэн?	Юу?	Ямар?	Яав?



2. Эхээс зуны улирлын тухай бичсэнийг олж хичээнгүй сайхан бичээрэй.

Handwriting practice lines consisting of four sets of horizontal lines with a diagonal line on the left side, forming a grid for writing.



3. Эсрэг утгатай үгсийг бичээрэй.

- |               |               |
|---------------|---------------|
| том - .....   | сайн - .....  |
| хар - .....   | өндөр - ..... |
| дээр - .....  | урд - .....   |
| инээх - ..... | суух - .....  |
| цэвэр - ..... | дээр - .....  |



4. Доорх үгсийг оролцуулан загварын дагуу өгүүлбэр зохиогоорой.

Миний \_\_\_\_\_, \_\_\_\_\_, \_\_\_\_\_.  
 Надад \_\_\_\_\_ олон \_\_\_\_\_ сонирхолтой \_\_\_\_\_ ном \_\_\_\_\_ бий .  
 Чамд \_\_\_\_\_, \_\_\_\_\_, \_\_\_\_\_ ?  
 Чамайг \_\_\_\_\_, \_\_\_\_\_, \_\_\_\_\_ .  
 Чи \_\_\_\_\_, \_\_\_\_\_, \_\_\_\_\_ !



5. Зургийг нэрлээрэй. Өгүүлбэрийг бичихдээ цэгийн оронд -ын, -ийн тохирохыг бичээрэй.

Энэ аав ...



Энэ багш ...



Энэ эгч ...



Энэ уул ...



## Бүлэг II. ГЭР БҮЛ

### Зурагт толь



Зураач




Сувилагч



Зохион бүтээгч




Шоо



Хөдөө



Хор



Алаг нүд




Тэврэх



Үнэртэх



Хөөрхөн



Далай



Амрах



Нагац ах



Нагац эгч



Хүргэн ах



Бэр эгч



Тэнгэр



Галын дөл



Голын ус



Өд

## ДАСГАЛ 1



1. Баатарын гэр бүлийн танилцуулгыг уншаарай.

### Миний гэр бүл

Миний нэрийг Баатар гэдэг. Манайх ам бүл дөрвүүлээ. Миний аавыг Болат, ээжийг Анар, хөөрхөн дүүг минь Төмөр гэдэг. Би ааваасаа домбор тоглохыг сурсан. Ээж хөөрхөн хүүхдүүд минь миний амин эрдэнэ. Дүү зохион бүтээх сонирхолтой. Дүү бид хоёрын мөрөөдөл биелнэ гэж би итгэдэг. Тийм учраас хичээл номдоо шамдан суралцдаг.



2. Асуултад хариулж яриарай.

- А. Баатарын гэр бүл хэдүүлээ вэ? Нэрлэж хэлээрэй.
- Б. Баатар ааваасаа юу сурсан бэ?
- В. Баатарын дүү юу мөрөөддөг вэ?
- Г. Ямар үгсийг том үсгээр бичсэн байна вэ?



3. Баатарын гэр бүлийн хүмүүсийн сонирхол, хүсэл мөрөөдлийг уншаарай.

Миний нэр Баатар. 3-р ангийн сурагч. Зураг зурах дуртай. Би зургийн үзэсгэлэн гаргаж, зураач болохыг мөрөөддөг.

Аавыг Болат гэдэг. Уурхайд эмч ажилтай. Домбор тоглох дуртай. Надад домбор хөгжмөө өвлүүлэх хүсэлтэй.



Ээжийн нэр Анар. Тэр сувилагч мэргэжилтэй. Олон хүнийг эмчлэх хүсэлтэй.

Миний дүү 5 настай. Түүнийг Төмөр гэдэг. Шоогоор тоглох дуртай. Зохион бүтээгч болно гэж боддог.




4. Дээрх загварыг ашиглан өөрийн гэр бүлийн хүмүүсийн сонирхол, мөрөөдлийн тухай ярилцаад бичээрэй.



5. Дараах асуултын дагуу бичээрэй.

- А. Чамайг хэн гэдэг вэ?
- Б. Ам бүл хэдүүлээ амьдардаг вэ?
- В. Гэр бүлийн гишүүдийн нэр, нас, ажил, сургуулийг танилцуулаарай.
- Г. Мөн тэдний хүсэл мөрөөдлийг бичээрэй.

 1. Шүлгийг уншаад, цээжлээрэй.




**Гурван эрдэнэ**


Алт гэвэл аавыг хэлнэ  
Ачтай сайхан итгэлийг хэлнэ


Эрдэнэ гэвэл ээжийг хэлнэ  
Энгүй сайхан сэтгэлийг хэлнэ


Нандин гэвэл найзаа хэлнэ  
Намайг гэсэн бодлыг хэлнэ

 2. Үгсийг давтан уншаарай.


Аавыг ээжийг	ачтай сайхан	итгэлийг сэтгэлийг	нандин булгыг	найзыг намайг
-----------------	-----------------	-----------------------	------------------	------------------

 3. Загварын дагуу уншиж, бичээрэй.





 4. Зөв өгүүлбэрийг сонгон бичээрэй.

- Хөдөөнөөс ирэв аав ээж
- Ирэв аав ээж хөдөөнөөс
- Аав, ээж хөдөөнөөс ирэв

 5. Дараах өгүүлбэрийн төгсгөлд зохих цэг тэмдгийг бичээрэй.

- А. Аав, ээж хөдөөнөөс ирэв
- Б. Миний хүү сайн явж ирэв үү
- В. Ногоон гэрэл асахад зам хөндлөн гараарай
- Г. Аав, ээжээ хайрлаарай

 6. Дээрх өгүүлбэрүүдээ хурааж бичээрэй.

 7. Дараах үйл үгээр өгүүлбэр зохиогоорой.

хайрлах, найзлах, ярих, бүжиглэх, тоглох,  
сурах, итгэх, зурах, заах, мөрөөдөх,

- Аав бичив. Бат явлаа. - хураангуй өгүүлбэр
- Аав хүүхдийн ном бичив. Бат гэрлүүгээ дугуйгаар явлаа. - дэлгэрэнгүй өгүүлбэр

## ДАСГАЛ 3



1. Зургийг ашиглаад асуулт тавьж ярилцаарай.



2. Асуултад хариулж бичээрэй.

- А. Зураг дээр хэдэн том хүн байна вэ?
- Б. Гэр бүлийн гишүүдийг нэрлээрэй.
- В. Ширээн дээр юу, юу байна вэ?
- Г. Өвөө нь юу хийж байна вэ?
- Д. Аав нь юу авч байна вэ?
- Е. Ээж нь юу хийж байна вэ?
- Ё. Зураг дээр хэдэн хүүхэд сууж байна вэ?
- Ж. Ямар амьтан байна вэ?



3. Буруу бичсэн үгсийг олоорой. Зөв болгон бичээрэй. Зүйр цэцэн үгийг цээжлээрэй.

Аавийн сургаал алт  
Ээжын сургаал эрдэм

Аавийн бийд хүнтэй танилц  
Агтний бийд газар үз



4. Дараах үгсэд -ын, -ийн, -ыг, -ийг залгаврыг зөв залган өгүүлбэр зохион бичээрэй.

айл

аймаг

ах


газар

дүүс

хөрш

найз

эмээ

 1. Шүлгийг цээжлэн үйл хөдлөлөөр илэрхийлэн уран уншаарай.

**Хаана байна вэ?**

Алаг нүд нь хаа байна?

Энэ байна

Аавыгаа би харж байна

Энхрийхэн чих нь хаана байна?

Энэ байна

Ээжийгээ би сонсмоор байна

Алив гар нь хаа байна?

Энэ байна

Аавыгаа, ээжийгээ тэвэрмээр байна

Хөөрхөн хамар нь хаа байна?

Энэ байна

Хөргөгчнөөс алим үнэртээд байна


Ярьдаг ам нь хаа байна?

Энэ байна


Яруу шүлэг уншмаар байна

О. Сундуй




 2. Доорх үгсийг уншаарай. Дэвтэртээ хичээнгүй бичээрэй.

алаг, энхрийхэн, чих, хаана, сонсмоор, тэвэрмээр, хөргөгчнөөс, үнэртээд, яруу шүлэг, уншмаар, хөөрхөн, ярьдаг, харж байна

 3. Асуух өгүүлбэрийг ялган бичээрэй.

Handwriting practice lines consisting of five columns of horizontal lines with diagonal lines separating them.

 4. Ойролцоо утгатай үгсийг нөхөж нэрлээрэй.

хөөрхөн - гоё, сайхан, .....

харах - ....., ....., .....

хүн - ....., ....., .....

ТОМ - ....., ....., .....

явах - ....., ....., .....

## ДАСГАЛ 5



1. Эхийг уншаарай.

### Манайхан

Намайг Сугар гэдэг. Манайх ам бүл тавуулаа. Миний аавыг Баяраа гэдэг. Аав маань жолооч. Ээжийг Жаргалмаа гэдэг. Ээж маань оёдолчин. Дүүг Тэмүүлэн гэдэг. Эгчийг маань Цэцэгмаа гэдэг. Бид чөлөөт цагаа хөгжилтэй, зугаатай өнгөрөөдөг. Өнгөрсөн зун бид Хөвсгөл далайд амарсан.













2. Асуулт зохиож ярилцаарай.

А. Сугарын гэр бүлийн тухай 3-5 асуулт зохиогоорой.

Б. Зохиосон асуултаа бусдаас асуугаарай.



3. Загварын дагуу бичээрэй.

..... ээж .....	Оюуны авга эгч захирал	..... нагац ах .....	..... бэр эгч .....	..... ах .....					
									
..... дүү .....	..... эгч .....	..... ах .....	..... нагац эгч .....	Жаргалын аав багш					

1. Зургийн дагуу хэн хэнд, яаж тусалж байгааг ярилцаарай.




2. Асуултад хариулаарай.

- Эмээгийнд хэн хэн туслахаар ирсэн бэ?  
.....
- Эмээгийн ач хүү, зээ охин юу хийж байна вэ?  
.....
- Ээждээ охин нь яаж тусалж байна вэ?  
.....
- Чи байсан бол хэнд, яаж туслах вэ?  
.....

3. Тар нар гэрийнхэндээ яаж тусалдаг талаар бусдад ярьж өгөөрэй.

4. Доорх загварыг гүйцээн бичээд, өгүүлбэр зохиогоорой.



## ДАСГАЛ 7



1. Ертөнцийн гурвыг уншаад цээжлээрэй.

Ертөнцийн гурван сайхан  
Элэгсэг санахад ээж сайхан  
Эрхэлж наадахад эцэг сайхан  
Эргэж бодоход нөхөд сайхан

Ертөнцийн гурван хөх  
Уужим дэлхийн тэнгэр хөх  
Унтрах галын дөл хөх  
Урсах голын ус хөх



2. Давтан уншаарай.

ээж  
эцэг  
нөхөд

сайхан

хөх

тэнгэр  
галын дөл  
голын ус



3. Ертөнцийн гурвыг гүйцээж бичээрэй.

Ертөнцийн гурван .....

Хөх тэнгэр



ээр баян

Хөрст газар



ээр баян

Хөлгүй далай



аар баян

Ертөнцийн гурван хөнгөн

Урсахдаа



нэг .....

Хийсэхэд



нэг .....

Өргөхөд



нэг .....



4. Ертөнцийн гурвыг дэвтэртээ бичээд цээжлээрэй.

Өсөхөд

шүд

Өтлөхөд

үс

Үхэхэд

яс

цагаан



1. Шүлгийг уран тод уншаарай.


Хүү

Аав ээж намайг  
Төрсөн хүү минь гэх юм  
Аавын аав, ээж бол  
Ач хүү минь гэх юм.

Ээжийн ээж, аав бол  
Зээ хүү гэх юм  
Эх орондоо би бол  
Эзэн хүү нь билээ!



2. Загварын дагуу шүлгийг уншиж яриарай. Бичээрэй.



3. Өгүүлбэрүүдийг гүйцээн бичээрэй.

Аавын талыг ..... гэдэг. Ээжийн талыг ..... гэдэг. Миний авга ахын нэр..... Миний нагац эгчийн нэр..... Өвөө ..... хүүдээ үлгэр ярьж өгөв. Эмээ ..... охиндоо хоол хийхийг заав.



4. Зургийн ажиглаарай. Чи чөлөөт цагаараа юу хийдэг вэ? Ярилцаарай.



## ДАСГАЛ 9



1. Эхийг уншаарай.

### Алагхан шувуухай

Амар хүү өвөөтэйгөө ойд зугаалж явав. Нэгэн алаг шувуу өндөр модны мөчир дээр суугаад, сэргэлэн дуугаар дуугарч байв. Амар хүү түүнийг харснаа:  
- Өвөө энэ шувуу юу гэж байгаа юм бол гэж сонирхон асуув. Өвөө нь өнөөх шувууг харж инээмсэглэж байснаа,  
- Модны мөчир битгий хугалаарай л гэж байна гэв.



2. Асуултын дагуу яриарай.

- А. Амар өвөөтэйгөө хаана явж байсан бэ?
- Б. Тэр юу харсан бэ?
- В. Амар өвөөгөөсөө юу гэж асуусан бэ?
- Г. Өвөө нь юу гэж хариулсан бэ?
- Д. Модны мөчрийг хугалбал яах вэ?



3. Эхийн үйл явдлыг зургийн дагуу ярилцаарай.



4. Хүүгийн асуусан, өвөөгийн хариулсан хэсгийг ялгаж бичээрэй.



5. Эхээс 2 хүүрнэх өгүүлбэр олж бичээрэй.



6. Холбоо үгсийг уншиж, өгүүлбэр зохиогоорой.

Өвөөгийн  
сайн  
тусч  
ажилсаг  
нямбай  
шударга

хүү

Өвөөгийн хүү ойд очив.

.....  
.....  
.....  
.....  
.....

## Бүлэг III. СУРГУУЛЬ

### Зурагт толь



хог



цаас



дугуйлан



номын сан




үйлчлэгч



тогооч



манаач



дотуур байр




биеийн  
тамирын заал



цайны газар



тоглоомын  
талбай



хичээлийн  
хуваарь




сурах бичиг



хаях




цэцэг услах




самбар арчих




талархал



хэвтээ



аюултай



түлхүүр

## ДАСГАЛ 1



1. Эхийг уншаарай.

### Манай анги

Энэ манай **анги**. Бид ангиа үргэлж цэвэрлэдэг. Ангидаа **хог**, цаас хаядаггүй. Өдөр бүр жижүүр сурагч самбарын алчуурыг бэлтгэн, ангийн ариун цэвэрт анхаардаг. Байнга цэвэр агаар оруулж, **эмх** цэгцтэй, цэвэрхэн суудаг. Бид сургуулийн үйлчлэгчийг хүндэлж, тэдэнд үргэлж тусалдаг.



2. Сурагчдын ангидаа хийдэг зүйлсийг сонгон уншаарай.



3. Тодруулсан үгсийг зөв уншиж сураарай.



4. Үгсийг харьцуулж уншаад, өгүүлбэрт оруулан яриарай.

хог  
хаягдал

Бид ..... хогийн саванд хийдэг.  
..... цаасаар бүтээл хийв.

байнга  
үргэлж

Би дүүдээ ..... тусалдаг.  
..... инээж яваарай.

эмх цэгцтэй  
замбараатай

Ангидаа ..... суух нь зөв.  
..... байх чухал.

инээх - баясах - хөхрөх  
үргэлж - байнга - дандаа

ойролцоо үг

цэвэр - бохир, зөв - буруу  
суух - босох, ирэх - явах

эсрэг үг


1. Зүйр цэцэн үгийг уншаад цээжлээрэй.


**Сайныг** дагавал сарны гэрэл  
**Мууг** дагавал могойн хор

**Инээсэн** бүхэн найз биш  
**Уурласан** бүхэн дайсан биш

2. Тодруулсан үгсийг дахин уншаад ямар үг болохыг ярилцаарай.

3. Зургийг нэрлэн өгүүлбэр зохиож дэвтэртээ бичээрэй.

Энэ ..... 

Энэ ..... 

Энэ ..... 

Энэ ..... 


4. Үгсийг зөв байрлуулан өгүүлбэр зохиож бичээрэй.

байна, Цонхон, дээр, цэцэг.  
миний, Энэ, сандал.  
жижүүр, Ангийн, услав, цэцэг.  
Сурагч, арчив, самбар  
ангид, хичээлээ, Бид, хийв.

5. Тохирох залгаврыг залгаад холбоо үг үүсгэн бичээрэй.



<b>НОМ</b>	- ҮН	<b>сан</b>	<b>эмч</b>	- ҮН	<b>өрөө</b>
	- ИЙН			- ИЙН	
<b>самбар</b>	- ҮН	<b>алчуур</b>	<b>эгч</b>	- ҮН	<b>зураг</b>
	- ИЙН			- ИЙН	


## ДАСГАЛ 3

 1. Талархал бичиж суръя.


### Талархал бичихдээ:

- ✓ Хэнд бичиж байгаа
- ✓ Талархаж байгаагийн учир
- ✓ Талархлыг бичиж байгаа хүний нэр
- ✓ Он, сар, өдөр




 2. Асуултад хариулаарай.

- А. Хэнд бичсэн талархал байна вэ?
- Б. Талархлыг хэн бичсэн байна вэ?
- В. Яагаад талархах болсон бэ?

 3. Зургийн дагуу өгүүлбэр зохиож ярилцаарай.



 4. Хэн, юу гэсэн асуултад хариулагдах үгсийг ангилан бичээрэй.

Хэн ?	Юу?


1. Ангийн дүрмийг уншаад мөрдөөрэй.



2. Ангийн дүрмийн дагуу тоочин бичээрэй.

Юу?	Яах?
цаг	
хог	
хичээлд	
хувцас	

3. Түлхүүр үг ашиглан ангийн дүрэм зохион бичээрэй.



4. Алдаатай үгийг олж зөв бичээрэй.

Бид хичээлын дэгээ баримталдаг. жижүүр багшын ширээг арчив. Номийн тавиурт олон ном байна. Сурагчын дэвтэр цэвэрхэн байх ёстой.

Алдаатай бичсэн үг: \_\_\_\_\_

Алдаагүй бичсэн үг: \_\_\_\_\_

## ДАСГАЛ 5



1. Зөвлөмжийг ойлгож уншаад, дэвтэртээ бичээрэй.

1. Хэвтээгээрээ битгий



уншаарай.

2. Юм уншиж байхдаа хагас цаг тутам



амрааж байгаарай.

3.



байнга харах нь нүдэнд аюултай.

4. Өдөрт 2 цагаас илүү



үзэж болохгүй.



2. Асуултад хариулаад бичээрэй.

- Чи өдөрт хэдэн цаг зурагт үздэг вэ?

- Долоо хоногт хэдэн цаг номын санд суудаг вэ?

- Танай ангийн хичээл хэдэн цагт эхэлж, хэдэн цагт тардаг вэ?



3. Зүйр цэцэн үгийг цээжлээрэй.

Эрдэмтэй хүн даруу  
Их мөрөн дөлгөөн

Эд хураахаар  
Эрдэм хураа



4. Үгсийг зөв дараалалд оруулан өгүүлбэр бүтээж, цэвэр сайхан бичээрэй.

ЭХЛЭВ

ХОНХ

ӨМСӨЖ

ДҮРЭМТ


ХИЧЭЭЛ

СУРГУУЛЬД

ХУВЦСАА


БАЙГААРАЙ


ДУУГАРЧ

 1. Эхийг уншаарай.

**Сургууль**

Сургуульд олон хүн ажилладаг. Сургуулийн захирал, сургалтын менежер, багш, эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, нягтлан бодогч, номын санч манаач, үйлчлэгч, тогооч гэсэн мэргэжилтэй хүмүүс ажилладаг. Сургуулийн номын санд сурах бичгүүд, унших номууд байдаг. Хичээл хуваарийн дагуу ордог. Сурагчид янз бүрийн дугуйланд суралцдаг. Сургуулийн цайны газраас бид үдийн цай уудаг. Биеийн тамирын зааланд бөмбөг тоглодог. Сургуулийн эргэн тойронд тоглоомын талбай байна.


 2. Тодруулсан үгсийг дахин давтан зөв уншаарай.

 3. Асуултын дагуу яриарай.

- А. Сургуульд хэн хэн ажилладаг вэ?
- Б. Номын санд юу байдаг вэ?
- В. Танай сургуулийн эргэн тойронд юу юу байдаг вэ?


 4. Дээрх эхээс дэвтэртээ бүлэглэн бичээрэй.

-ЫН, ЫГ	
-ИЙН, ИЙГ	
хэн?	
юу?	
яав?	
хэд?	

 5. Өгүүлбэрүүдийг гүйцээн өөрийнхөө сургуулийг танилцуулж, хичээнгүй бичээрэй.

Манай сургууль ..... аймгийн ..... сумын ..... сургууль юм. Манай сургуульд .... багш ажилладаг, бас ... сурагч сурдаг. Сургуулийн захирлын нэрийг ....., сургалтын менежерийн нэрийг ..... гэдэг. Манай сургуульд ....., ....., ....., ..... байна. Сургуулийн хажууд ....., ....., ..... байдаг. Биеийн тамирын хичээл ..... ордог. Сурагчид үдийн хоолыг ..... газарт иддэг.


## ДАСГАЛ 7

 1. Үргэлжлүүлэн харилцан ярилцаарай.




Чи аль сургуульд сурдаг вэ?

.....  
.....  
.....



Танай анги өдөрт хэдэн цагийн хичээл ордог вэ?

 2. Зүйр цэцэн үгийг уншаад, утгыг мэдэн тогтоогоорой.

Эрдэнэ ховор боловч олж болдог  
Эрдэм гүн боловч сурч болдог

Эрдмийн  
түлхүүр  
ном

Далай хязгааргүй  
Эрдэм оройгүй


 3. Түлхүүр үг ашиглан ангийн багшдаа талархал бичээрэй.

Эрдэм ном, баярлалаа, заасан, үсэг таниулсан, бахархдаг

Багш М.Айнагүлд  
Эрдэм номын үсэг бүрийн учрыг таниулж,  
уншуулж, бичүүлж сургасан багш тандаа маш  
их талархаж байгаагаа илэрхийлье.

Сурагч. М.Муратаас  
2023 оны 9 дүгээр сарын 1

Талархал нь  
бусдын ач тусад  
баярласан сэтгэлээ  
илтгэх үг хэллэг,  
үйлдлийг хэлнэ.





1. Дууны үгийг цээжлээд дуулаарай.



Үг: Б.Ганхуяг

Ая: Ц.Гүррагчаа

**Алтан ном дэлгээд угтлаа**

- |  |  |
|--|--|
| 1. Эрдмийг дээдлэх<br>Монгол ёсоо<br>Ээж аав шигээ<br>Дээдлэх хувьтай яа           | 3. Ухааныг дээдлэх<br>Дээдсийн ёсоо<br>Ус нутаг шигээ<br>Хайрлах хувьтай яа        |
| 2. Аавтайгаа, ээжтэйгээ<br>Ашдын заяагаа дагаад ирэхэд<br>Алтан ном дэлгээд угтлаа | 4. Аавтайгаа, ээжтэйгээ<br>Ардын сургуульд ороод ирэхэд<br>Ачит багш тосоод угтлаа |
| 5. Номдоо мөргөх<br>Өвгөдийн ёсоо<br>Өвлөн авах<br>Буян заяатай яа                 | 6. Аавтайгаа, ээжтэйгээ<br>Ашдын заяагаа дагаад ирэхэд<br>Алтан ном дэлгээд угтлаа |



2. Холбоо үгсийг зөв уншаад дэвтэртээ бичээрэй.

ачит багш

өвгөдийн ёс

алтан ном

ардын сургууль

монгол ёс

ном дэлгэх

## ДАСГАЛ 9



1. Шүлгийг уран тод уншаад цээжлээрэй.



### Багшаа би би

Цэвэрхэн бичсэн шүлгээ  
Цээжээр уншъя, би би  
Шинэхэн сурсан дуугаа  
Шимтэн дуулъя, би би  
Багшаа, багшаа би би

Уншиж мэдсэн үлгэрээ  
Утгыг ярья, би би  
Урлан зурсан зургаа  
Учрыг нь хэлье, би би  
Багшаа, багшаа би би

Г. Хүрэлбаатар



2. Холбоо үгсийг зөв уншаад өгүүлбэр зохиогоод, яриарай.

Цээжээр унших

Цэвэрхэн бичих

Будгаар зурах

Уншиж мэдэх

Шинээр сурах

Гоё дуулах

Учрыг хэлэх



3. Дараах үгсийг дэвтэртээ бичээд зөв уншаарай.

явъя суръя дуулъя харъя мэдье өгье үзье  
ирье уншъя ярья таръя хэлье авья олъё



4. Дээрх үгсийг эр, эм үгээр нь ялгаж бичээд, өгүүлбэр зохиогоорой.

Эр үг	Эм үг

*Ангиараа ном уншъя.*

## Бүлэг IV. АЖИЛ ХӨДӨЛМӨР

### Зурагт толь



сэрэх



босох



хоцрох



тоглох




туслах




уулзах



ярилцах




хол



ойр



наана



цаана



цагийн зүү



ороо хураах



унтах



амрах



зүү сүлбүүр




уулзах



угаах



өмсөх



мөнгө зарцуулах

## ДАСГАЛ 1




1. Харилцан яриаг хосоороо уншаарай.



Очир

Өглөөний мэнд найз аа. Танайх энд байдаг юм уу?

Өглөөний мэнд, сайхан амарсан уу?  
Тийм, манайх энэ байранд амьдардаг.



Чимгээ



Манайх хоёрдугаар байрны цаана байдаг. Хоёулаа хичээлдээ хамт явж байя.



За тэгье. Чи өглөө хэдэн цагт босдог вэ?

Би өглөө 7 цагт босоод, өглөөний цайгаа уудаг.  
Тэгээд 7 цаг 30 минутад гэрээсээ гардаг.



Хөөх, би заримдаа 7 цаг 20 минутад босоод өглөөний цайгаа ууж чаддаггүй. Хоцрохгүйн тулд 7 цаг 35 минутад гэрээсээ гардаг.



Аа, тэгвэл миний найз өглөөний цайгаа заавал ууж байгаарай.



Би хичээлээ тараад бүжгийн дугуйланд явдаг.  
Харин чи юу хийдэг вэ?

Би хичээлээ тараад, гэртээ харихад өдөр 2 цаг 25 минут болж байдаг. Даалгавраа хийгээд, дүүтэйгээ тоглоно бас гэрийн ажилд тусалдаг.



Би дугуйлангаа тараад, 16 цагт гэртээ харьдаг. Хамт гэрийн даалгавраа хийх үү?


Харин ээ, чамайг хүлээхээр орой болчих юм байна.




Баяртай найз аа. Өглөө уулзъя.


Маргааш ярилцъя. Баяртай.




 2. Очир, Чимгээ нарын өдөрт хийдэг үйлдлийг тоочин бичээрэй.


Очир		өглөө .....	Чимгээ		өглөө .....
		өдөр .....			өдөр .....
		орой .....			орой .....

 3. Зөв өгүүлбэрийг сонгож бичээрэй.

Очир: Чимгээгийнх манайхаас		ойр.	Чимгээ		эрт босдог.
		хол.			орой босдог.

Хоёр байрны		цаана		Чимгээгийнх байдаг.
		наана		

 4. Тохирох хугацааг нөхөж уншаарай.



Минутын зүү


Цагийн зүү



Цаг

Минут

Хүүхдүүдийн хичээл 8 цагт эхэлдэг. Очир ..... минут, Чимгээ ... минут сургууль руу алхдаг. Манай хичээл .... цагт эхэлдэг. Би сургууль руу ... минут явдаг.


 5. Тохирох асуулт, хариултыг дэвтэртээ бичээрэй.

АСУУЛТ

.....  
 Чи өглөөний цайгаа тогтмол уудаг уу?  
 .....

ХАРИУЛТ

Би өглөө 8 цагт босдог.  
 .....  
 Хичээлээ тараад 18 цагт харьдаг.

 6. Доорх түлхүүр үгсийг ашиглан ярилцаарай.




Би

Ашиглах үгс  
 Өглөө, өдөр, орой, босдог,  
 унтдаг, сургуульдаа явдаг



Найз


## ДАСГАЛ 2

-  1. Дууны үгийг цээжлээрэй.


### Цаг

Алтан дэлхий цагтай  
Ажил төрөл цагтай  
Наран саран цагтай  
Наадам тоглоом цагтай  
Хүний хэлсэн цагийг  
Юугаар ч нөхөж болохгүй  
Хэлгүй хэлсэн цагтай  
Хэнд ч найдаж болохгүй  
Цаг чаг чаг




-  2. Дууны үгийг зурагтай холбоорой.




-  3. Дууны үгээ цээжээр дэвтэртээ бичээрэй.

Бичихдээ:

1. Номоо хаагаарай.
2. Мөр мөрөөр нь бичээрэй.
3. Бичсэнээ шалгаарай
4. Алдаагаа засаарай.

-  4. Дууны үгээс доорх асуултад хариулаарай.

- А. Ц үсэгтэй үг хэд байна вэ? Дэвтэртээ ялгаж бичээд, зөв уншаарай.
- Б. Ч үсэгтэй үг хэд байна вэ? Дэвтэртээ ялгаж бичээд, зөв уншаарай.
- В. Хамгийн олон давтагдсан үгийг бичээрэй.


 1. Онъсогыг таагаад, ярилцаарай.

Тог тог дуутай  
Тоогоор дүүрэн нүүртэй



Арван хоёр өртөөтэй  
Өртөө бүр хэмжээтэй  
Албаны хоёр элчтэй  
Элч бүр тушаалтай

Тодруулсан  
үсэг, үеийг  
ажиглаарай.

 2. Өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.

Цагийн зүү урт, харин минутын зүү ..... Болдоо эрт босдог, харин Туяа эрт .....



өндөр, харин




.....



өдөр, харин



..... гардаг.


 3. Эсрэг утгатай өгүүлбэрийг зохиож бичээрэй.



Жишээ нь: Наран номоо цүнхэндээ хийв.  
Наран номоо цүнхнээсээ гаргав.

Наран өглөө эрт босов. ....

Наран ширээн дээр дэвтрээ тавив. ....

Наран өнөөдөр хотоос ирнэ. ....

 4. Зургийг ажиглаад, өгүүлбэр зохиогоорой.



## ДАСГАЛ 4



1. Цэрэн, Чимгээ нарын нэг өдрийн үйл явдлыг тоочин яриарай.



Цэрэн юу, юу хийдэг вэ?

1. Өглөө босов.
2. Ороо хураав.
3. ....
4. ....
5. ....
6. ....
7. ....
8. ....
9. ....
10. ....
11. ....

Чимгээ юу, юу хийдэг вэ?

1. Өглөө босов.
2. Цэрэнтэй хамт дасгал хийв.
3. ....
4. ....
5. ....
6. ....
7. ....
8. ....
9. ....
10. ....
11. ....



## 2. Нэг өдөрт юу хийдэг тухайгаа яриарай.

Танай ангийн хичээл хэдэн цагт ордог вэ?

1

Хэрэв чи **өглөө** хичээлдээ явдаг бол дараах асуултад бүтэн өгүүлбэрээр хариулаарай.

- Чи өглөө хэдэн цагт босдог вэ?
- Ороо хураадаг уу?
- Өглөөний цайгаа тогтмол уудаг уу?
- Өглөө хэдэн цагт гэрээсээ гардаг вэ?
- Сургууль хүртэл ямар хугацаа зарцуулдаг вэ?
- Үдийн хоолоо хэдэн цагт иддэг вэ?
- Хичээл нь хэдэн цагт тардаг вэ?
- Гэртээ хариад юу, юу хийдэг вэ?
- Танайх оройн хоолоо хэдэн цагт иддэг вэ?
- Оройн хоолоо хийсний дараа юу хийдэг вэ?
- Хэдэн цагт унтдаг вэ?

2

Хэрэв чи **өдөр** хичээлдээ явдаг бол дараах асуултад бүтэн өгүүлбэрээр хариулаарай.

- Чи өглөө хэдэн цагт босдог вэ?
- Ороо хураадаг уу?
- Өглөөний цайгаа тогтмол уудаг уу?
- Өглөөний цайгаа уусны дараа юу, юу хийдэг вэ?
- Өдөр хэдэн цагт сургууль руугаа явдаг вэ?
- Замдаа хэн, хэнтэй хамт явдаг вэ?
- Сургуульдаа очтол хэдэн минут алхдаг вэ?
- Машинаар эсвэл автобусаар явдаг бол хэдэн минут явдаг вэ?
- Хичээл нь хэдэн цагт тардаг вэ?
- Оройн хоолоо хэдэн цагт иддэг вэ?
- Оройн хоолны дараа юу хийдэг вэ?
- Хэдэн цагт унтдаг вэ?



## 3. Найзынхаа өглөөнөөс орой хүртэл юу хийдгийг нь асууж дэвтэртээ бичээрэй.

- Хэрэв найз чинь өглөө хичээлдээ явдаг бол нэгдүгээр асуултын дагуу бичээрэй.
- Хэрэв найз чинь өдөр хичээлдээ явдаг бол хоёрдугаар асуултын дагуу бичээрэй.
- Бичсэнээ багшдаа шалгуулаарай.
- Дахин сайжруулж бичээрэй.

## ДАСГАЛ 4



1. Эхийг уншаарай.

### Өдрийн дэглэм

Бидний өдөр тутам хийдэг ажил байнга давтагдаж байдаг. Жишээ нь: Өглөө босох, цайгаа уух, гэрийн даалгавар хийх, сургуульдаа явах, орой унтах гэх мэт.

Өдрийн дэглэмээ сайн баримталж, цагтаа босож, гэрийн даалгавраа хийж, гэрийн ажилд тусалж, ном уншиж, тоглож, унтаж амарч сурах хэрэгтэй. Ажил, амралтын цагаа зөв зохицуулж байгаа нь өдрийн дэглэмээ сайн баримталж байгаа гэсэн үг юм. Цагаа зөв ашиглаж, ажлаа цагтаа хийж өдрийн дэглэмээ сайн баримтлаарай.



2. Эхээс асуултын дагуу сонгож уншаарай.

1. Өдөр тутам ямар ажил давтагдаж байдаг вэ?
2. Та нар өдрийн дэглэмээ баримталж, ямар ямар ажил хийж сурах хэрэгтэй вэ?
3. Өдрийн дэглэмээ баримтлахын тулд цагаа яаж зөв зохицуулах вэ?



3. Зургийн дагуу өгүүлбэр зохиогоорой.



## Бүлэг V. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

### Зурагт толь



эх орон



хил



байгаль



газрын зураг



амины сууц



хотхон



орон сууц



гэр барих



завь



хөлөг онгоц



ачааны машин



нисдэг тэрэг




гэрийн хана



гэрийн тооно



гэрийн багана



гэрийн унь



илжиг



үхэр тэрэг



баруун, зүүн



ундаг дугуй

## ДАСГАЛ 1



1. Ойлгож уншаарай.

### Манай аймаг

Бид Баян-Өлгий аймагт амьдардаг. Манай аймаг Монгол орны баруун зүгт байдаг. Баян-Өлгий аймаг 13 сум, 1 тосгонтой. Аймгийн төвийг Өлгий сум гэдэг. Өлгий сум 13 багтай. Манай аймаг халх, казах, урианхай, дөрвөд, тува хүмүүс эвтэй найртай амьдардаг.



2. Цэгийн оронд тохирох үгийг оролцуулж яриарай.

Би ..... амьдардаг. Манай ..... том. Манай ..... багтай. Манай ..... олон ..... байдаг.



3. Зурагт ямар өнгөөр юу, юуг харуулсан тухай ярилцаарай.



алтан шар соёмбо

хөх .....


.....

.....

.....



4. Цэгийн оронд “ын, ийн” залгаврыг тохирохыг нөхөөд, өгүүлбэр болгож бичээрэй.


Манай  баг .....  
сум .....  
тосгон.....  
аймаг.....




Жишээ нь: Манай багийн сургууль.

- Эр, эм үгэнд “**Ы, ИЙ**” нөхцөлийг зөв залгаж бичнэ. Жишээ: ном**ЫН**, багш**ИЙН**, ээж**ИЙН**
- Хэд, хэдэн гэдэг асуултад тоог нэрлэсэн үг бичнэ.  
**хэд?** - тав, **хэдэн?** - таван

1. Шүлгийг цээжлээрэй.



2. Шүлгийн утгыг ярилцаарай.



3. Үгсийг харьцуулж, зөв дуудан, уншаарай.

сум - сумын  
гэр - гэрийн

аймаг - аймгийн  
хот - хотын

хил - хилийн  
эх орон – эх орны

4. Тохирох үгийг нөхөж бичээрэй.

..... санасан.

..... санасан.

..... санасан.

..... санасан.

..... санасан.

..... санасан.

5. Цэгийн оронд “ын, ийн” нөхцөлийг тохирохыг нөхөөд, өгүүлбэрүүдийг хичээнгүй бичээрэй.

сум ....  
аймаг ....  
улс ....  
эх орон....


хил

Газрын зурагт сум, аймаг, улсын хил нь өөр өөр тэм-дэг-лэ-гээ-тэй.  
Баян-Өлгий аймаг Увс, Ховд аймагтай хил-лэ-дэг.  
Монгол улс Орос, Хятад улстай хил-лэ-дэг.  
Манай эх орон уудам.

## ДАСГАЛ 3



1. Зургийн дагуу ярилцаарай.



Толбо нуур



Алтай Таван Богд



Бага түргэний хүрхрээ



2. Асуултын дагуу ярилцаарай.

1. Зураг дээр юу, юу байна вэ?
2. Ямар, ямар улирлын зураг байна вэ?
3. Эдгээр байгалийн үзэсгэлэнт газрууд хаана, хаана байдаг вэ?



3. Ойлгож уншаарай.

### Манай аймгийн байгалийн үзэсгэлэнт газрууд

Манай аймаг **Алтай Таван Богд уул**, **Бага түргэний хүрхрээ**, **Толбо нуур** гэх мэт байгалийн үзэсгэлэнт газартай. Алтай Таван Богд уул ба Бага түргэний хүрхрээ нь **Цэнгэл** сумын нутагт байдаг. Толбо нуур Толбо сумын нутагт байдаг.



4. Тодруулсан үгсийг ангилан бичээрэй.


Уулын нэр	Гол, нуурын нэр	Хүрхрээний нэр	Сумын нэр



5. Амьдардаг газрынхаа тухай танилцуулан бичээрэй.

Би ..... аймгийн  
..... суманд  
амьдардаг. Манай .....  
төвд ....., ....., .....  
..... байдаг. ....,  
..... үзэсгэлэнт газрууд манай  
..... бий.

Түлхүүр үг:  
 аймаг, сум, тосгон, баг  
 сургууль, цэцэрлэг,  
 дэлгүүр, эмнэлэг, соёлын  
 төв, номын сан  
 үзэсгэлэнт газрын нэр

 1. Зургийг ажиглаад, асуултын дагуу хариулж, яриарай.

Энэ юу вэ?




Энэ бол .....

Энэ бол .....

Энэ бол .....

**Ашиглах үгс:** амины сууц, орон сууц, хотхон


 2. Харилцан ярилцаарай.


Болор: -Танайх ямар сууцанд амьдардаг вэ?


Ариунаа: -Манайх амины сууцанд амьдардаг.

Ариунаа: -Танайх ямар хотхонд амьдардаг вэ?

Болор: -Манайх Алтан намар хотхонд амьдардаг.

 3. Дараах үгсийг зөв уншиж, холбоо үг бүтээн бичээрэй.



 4. Эдгээр холбоо үгсийг оролцуулан өгүүлбэр зохион бичиж, уншиж өгөөрэй.

_____	_____	_____	_____ ?
_____	_____	_____	_____ ?
_____	_____	_____	_____ ?

Асуух, хүүрнэх өгүүлбэрийг ялгаж, цэг тэмдгийг хэрэглэнэ.  
**Асуух өгүүлбэр** – Энэ юу вэ? **Хүүрнэх өгүүлбэр** – Манайх гэрт амьдардаг.

## ДАСГАЛ 5



1. Ойлгож уншаарай.



2. Үгийн утгыг ярилцаарай.

Үг	Чиний бодлоор	Тайлбар тольд
Сууц		



3. Өгүүлбэрийг зөв утгаар бүтээгээрэй.

Гэр      дулаахан      хүнд

хүйтэн      нүүхэд      хөнгөн



4. Үг бүтээж, нэрлэн бичээрэй.

а н ч      а н ч      о н о      а н ч

у ш      у а      у ш      б а

т к      х к      т ь      т г




5. Эсрэг утгатай үгсийг зурагт харгалзуулан тайлбарлаарай.

босох-суух      хөнгөн-хүнд      барих-буулгах      дулаан-хүйтэн


 1. Зургийг нэрлээрэй.




 2. Уншаарай.

**Тээврийн хэрэгсэл**

Тээврийн хэрэгслийг хуурай газрын, усан болон агаарын замын гэж ангилдаг. Хуурай газрын тээврийн хэрэгсэлд суудлын болон ачааны машин, моторт дугуй, унадаг дугуй, автобус, мотоцикль зэрэг орно. Усан тээврийн хэрэгсэлд хөлөг онгоц, моторт завь орно. Агаарын тээврийн хэрэгсэлд нисэх онгоц, нисдэг тэрэг багтдаг.

 3. Асуултын дагуу ярилцаарай.


- А. Тээврийн хэрэгслүүд ямар, ямар замаар явдаг вэ?
- Б. Хуурай газрын тээврийн хэрэгслүүдийг нэрлээрэй
- В. Хөлөг онгоц ямар төрлийн тээврийн хэрэгсэл вэ?



 4. Бүлэглэн бичээрэй.



Хуурай газар  
.....  
.....


Усан зам  
.....  
.....

Агаар  
.....  
.....

 5. Өгүүлбэрийг дэвтэртээ бичээрэй.

Миний ах  - **аар** хөдөө явлаа. Аав хотоос  - **оор** ирэв.

Хөвсгөл нуураар  - **оор** аялав. Улаанбаатар хотоос  - **аар** ирэв.

 6. Өгүүлбэрийг дэвтэртээ бичээрэй.

нисэх      дуртай      Би      онгоцоор

усан      явдаг      Усан онгоц      замаар

## ДАСГАЛ 7



### 1. Уншаарай.

Эрт үед хүмүүс морь, илжиг, үхэр, тэмээгээр явдаг байв. Хамгийн анх дугуйг бүтээжээ. Одоо тээврийн хэрэгслийн төрөл олон болсон. Холын газар онгоцоор зорчдог.



### 2. “-ы, -ий, ын, ийн” нөхцөлийг зөв залган бичээрэй.

Жишээ нь: Галт тэрэг**ний** тасалбар

зам .... тэмдэг  
агаар .... зам  
ойр.... гэрэл

машин..... дугуй  
онгоц..... нисгэгч  
ачаа..... машин

галт тэрэг... тасалбар  
илжиг.... ачаа  
үхэр тэрэг... дугуй



### 3. Харилцан ярилцаж, асуултад хариулаарай.



Энэ юу вэ?



Энэ бол үхэр тэрэг.



Сургуульдаа ямар тээврийн хэрэгслээр явдаг вэ?

Би алхаж явдаг. Манай гэр  
.....

Би сургуульдаа  
..... ирдэг.

Чи сургуульдаа юугаар ирдэг вэ?

Чи ямар тээврийн хэрэгслээр зорчих дуртай вэ?

..... дуртай.



### 4. Холбоо үг бүтээгээрэй.



..... тэрэг



..... тэрэг



..... тэрэг

Эр, эм үгэнд “**ЫН, ИЙН**” нөхцөлийг зөв залгаж бичиж суръя.  
Эр үг: замын, усны, холын  
Эм үг: үхрийн, хүмүүсийн

## Бүлэг VI. ЭРҮҮЛ АМЬДРАЛ

### Зурагт толь



Махан хоол



Цагаан идээ



Үр тариа



Жимс жимсгэнэ



Эзгий



Бяслаг



Өрөм



Шар тос



гурил



ногоотой хуурга



сармис



шар будаа



загас



тахияны мах



чавга



чацаргана



гүзээлзгэнэ



цагаан будаа




жимсний  
чанамал




өргөст хэмх



 1. Хоол хүнсний нэрийг зөв уншаарай.

Хуурга, лийр, загас, төмс, байцай, тахианы мах, ааруул, тараг, ногоотой шөл, чавга, алим, хоормог, жүрж, манжин, цагаан будаа, гурил, шийгуа, тарвас, чацаргана, мах, гүзээлзгэнэ, саримс, айраг, махан зууш, цагаан будаа, шар тос, үхрийн нүд, жимсний чанамал, жүүс, тараг, гадил, бялуу, зайрмаг, хиам, шар будаа, өргөст хэмх.

 2. Дээрх хоол хүнсний нэрийг бүлэглэн бичээрэй.


Махан хоол  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Цагаан идээ  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Жимс жимсгэнэ  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....


Үр тариа  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Хүнсний ногоо  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

 3. Холбоо үгсийг оролцуулан өгүүлбэр зохиогоорой. Дэвтэртээ алдаагүй, цэвэр сайхан бичээрэй.

Амттай хоол  
Амин дэм  
Эрүүл мэнд

Ногоо тарих  
Хоолны дэглэм  
Эрүүл хоол

 4. Асуултад хариулан бичээрэй.

Ямар сүү вэ?  
.....

Ямар хоол вэ?  
.....

Ямар жимс вэ?  
.....

**Сонгох үгс:** халуун, түргэн, өнгөгүй, өтгөн, чихэрлэг, амттай.

## ДАСГАЛ 3



1. Эхийг уншаарай.

### Чацаргана

Чацаргана жимс нь С амин дэм, хүчил, уураг тос гэх мэт хүний биед хэрэгтэй бодисоор баялаг жимс юм. Бүх жимсэнд амин дэмүүд байдаг

Чацарганаар шүүс, ундаа, чанамал хийж, тос гаргаж авдаг. Ханиад томуунд сайн. Чацарганы тосыг эмчилгээнд хэрэглэдэг.



2. Эдгээр үгсийг давтан уншаарай.



Чацаргана

Гүзээлзгэнэ

Бөөрөлзгөнө

жимс

жүүс

шүүс

чанамал



3. Асуултад бүтэн өгүүлбэрээр хариулаарай.

А. Чацаргана жимсэнд ямар амин дэм байдаг вэ?

Б. Чацаргана жимсээр юу, юу хийдэг вэ?

В. Чацарганы тосыг юунд хэрэглэдэг вэ?

Г. Ханиад томууны үед чацарганыг яаж хэрэглэх талаар ярилцаарай.




4. -ын,- ийн, -ыг, -ийг нөхцөлийг зөв залгаж бичээрэй.

жимс....., хүнсний ногоо....., амин дэм....., тос....., чацаргана.....,  
эмчилгээ....., ханиад томуу....., ундаа....., шүүс....., бодис....., чанамал.....



5. Цагаан идээг нэрлээд, өгүүлбэр зохиогоорой.





 1. Шүлгийг цээжлээрэй. Уран тод уншаарай.


**Монгол орон**

Тал сайхан нутагтай билээ  
Тансаг сайхан устай билээ  
Таван хошуу малтай билээ  
Тараг, айраг элбэгтэй билээ.




 2. Хос эгшигтэй үгсийг давтан уншаарай.

 3. Таван хошуу малын сүүгээр юу, юу хийдэг талаар ярилцаарай.


 4. Нөхөж бичээрэй.

Тэмээ..... сүү..... гэдэг.  
Гүү..... сүү..... гэдэг.



 5. Цагаан идээ бэлдэх аргыг уншаад, дэвтэртээ бичээрэй.



 6. Асуултад хариулан, өгүүлбэрийг гүйцээж бичье.

ямар?	юуг?	яадаг вэ?
Сэнгэнэсэн	айраг	исгэдэг.
	тараг	
Түүхий		хөөрүүлдэг
	тос	гаргаж авдаг

## ДАСГАЛ 5



1. Зүйр цэцэн үгсийг ойлгон уншаад, цээжлээрэй.



2. Зургийн дагуу өгүүлбэр зохиогоорой.



3. Эдгээр үгсэд тохирох асуултыг бичээрэй.

ажил - юу?            давс - .....?            мал - .....?  
мах - .....?            талх - .....?            тариа - .....?



4. Үгийг зөв дараалалд оруулж, өгүүлбэр болгон уншаад, дэвтэртээ бичээрэй.

1. Сонгино, байдаг, гашуун.
2. Эмээ, бүрэв, тараг
3. Миний, найз, гадил. идэх, дуртай
4. Малчин, Болдын, ах.
5. Уух, Миний, дуртай, дүү, сүү




5. Загварын дагуу бичээрэй.

..... > тарь            ..... > малла.            ..... > хий.

..... >

..... >

..... >

 1. Харилцан яриаг ойлгон уншаарай.



Чиний шүд гоё, цагаан  
өнгөтэй юм аа.

Тийм үү. Би цагаан идээ  
их иддэг болохоор л ийм  
гоё цагаан шүдтэй байх.

Аа мэдлээ, мэдлээ. Би ч  
гэсэн байнга цагаан идээ  
идээд байвал илүү цагаан  
шүдтэй болох юм байна шүү


Тийм ээ. Шүд эрүүл бол бие  
эрүүл байдаг гэсэн.

Монголчууд зуны цагт цагаан  
идээгээр хооллодог. Махан хоол  
бараг хэрэглэдэггүй байсан гэнэ  
лээ. Бас айраг гэж маш сайхан,  
биед сайн ундаа байдаг.


Яагаад цагаан идээ  
иддэг юм?



Эрүүл мэндэд маш тустай болохоор  
цагаан идээ идээрэй.




 2. Асуултад хариулан ярилцаарай.

- А. Шүдээ яаж эрүүл байлгах вэ?
- Б. Шүдээ хэзээ угаадаг вэ?
- В. Ямар хоол эрүүл мэндэд илүү тустай вэ?

 3. Загварын дагуу холбоо үг бүтээгээрэй.

 4. Өгүүлбэр зохиогоорой.

сайхан, гоё, амттай, эрүүл, гашуун, цагаан, давстай, махтай, жимстэй

## ДАСГАЛ 7



1. Эхийг ойлгон уншаарай.

### Хувийн ариун цэвэр

Хүн бүхэн өөрийн ариун цэвэрт сайн анхаарч, ариун цэвэр сахих нь чухал. Бид хувийн ариун цэврээ сахихдаа зарим алдааг гаргадаг байна.

#### 1. Шүдээ угаасны дараа усаар зайлдаг:

Шүдний эмч нар шүдээ угааж дуусгаад оог нулимж хаявал бидний шүдний эрүүл мэндэд тустай гэж зөвлөдөг. Шүдээ угаасны дараа усаар амаа зайлбал хамгаалах чанар нь багасдаг гэдэг.

#### 2. Самаа цэвэрлэдэггүй:

Үсний саманд нян хурдан үрждэг. Самаа байнга угааж байх хэрэгтэй.

#### 3. Гараа халуун усаар угаадаг:

Халуун усаар гараа угаавал нянтай тэмцдэг гэж ойлгодог. Халуун усаар угаасан гар амархан хуурайшдаг.

#### 4. Бие угаагч удаан хэрэглэдэг:

Бие угаагчийг хоёр сар тутам сольж байх хэрэгтэй. Хөнгөн цэвэрлэхэд амар бие угаагч сонгох хэрэгтэй.

#### 5. Шүршүүрт хөл нүцгэн ордог:

Усанд орохдоо хөлдөө зориулалтын шаахай өмсөж байгаарай. Учир нь шаланд олон төрлийн халдварт өвчний нян тархах эрсдэлтэй байдаг.



2. Бидний гаргадаг алдааг тоочин бичээрэй.

1. ....
2. ....



3. Асуултад хариулж ярилцаарай.

1. Шүдээ угаахдаа юуг анхаарах хэрэгтэй вэ?
2. Самаа яаж ашиглах хэрэгтэй вэ?
3. Гар ямар усаар угаах вэ?
4. Шүршүүрт хөл нүцгэн орох нь зөв үү? Яагаад?
5. Чи усанд орохдоо ямар бие угаагч хэрэглэдэг вэ ?



4. Үгсийг зөв байрлуулан өгүүлбэр зохиож бичээрэй.

унтахаас

Орой

угаагаарай.


шүдээ

өмнө

 1. Эхийг уншаарай.

**Гарын ариун цэвэр**

Гарын ариун цэврийг сахиснаар олон төрлийн халдварт өвчнөөс сэргийлнэ. Бохир гараа ам, хамар, нүдэндээ хүргэх, гар барих, биед нь хүрэх зэрэгт халдварт нян дамждаг. Гараа сайтар савандаж угаах эсвэл халдваргүйжүүлэгч хэрэглэж байх хэрэгтэй.


 2. Асуултыг бие биеэсээ асуугаад, харилцан ярилцаарай.

Хаана бохирдол их байдаг вэ?


- ❑ хаалганы бариул
- ❑ шат, шатны бариул
- ❑ зурагтын удирдлага
- ❑ гар утас
- ❑ суултуурын товч
- ❑ мөнгөн дэвсгэрт

Гараа хэзээ угаах вэ?

- ❑ гаднаас орж ирэхдээ
- ❑ хоол хийхийн өмнө
- ❑ хоол идэхийн өмнө
- ❑ хоол идсэний дараа
- ❑ бие зассаны дараа
- ❑ гадаа тоглосны дараа

 3. Асуултыг уншаад, хариулж бичээрэй.

1. Хаалганы бариул яагаад бохирдол ихтэй байдаг вэ?
2. Гар утсыг яаж ариутгаж хэрэглэвэл зүйтэй вэ?
3. Чи өдөрт хэдэн удаа гараа угаадаг вэ?
4. Гарын ариун цэврийг баримтлах нь ямар ач тустай вэ?

 4. Дараах үгсийн эсрэг утгыг бичээрэй.

цэвэр .....

өмнө .....


гадна .....

жаргал .....

хол .....

залуу .....

 5. Эхээс 3 дахь өгүүлбэрийг дэвтэртээ хичээнгүй бичээрэй.

 6. Гарын таван хурууг дэвтэртээ зураарай. Гар угаах дарааллыг бичээрэй.



## ДАСГАЛ 9



1. “Гал тогоонд” сэдвээр харилцан ярилцаарай.



2. Асуултад хариулан ярилцаарай.

Танай гал тогоонд юу, юу байдаг вэ?

.....

Танай гал тогооны сав суулгыг хэн цэвэрлэдэг вэ?

.....



3. Зөв, хурдан уншаарай.

Тогоо, данх, аяга, халбага, сэрээ, хувин, шанага, түмпэн, таваг, ус буцалгагч, цахилгаан зуух, цахилгаан тогоо, будаа агшаагч, хайруулын таваг, төмс шарагч

Миний ээж амттай хоол хийдэг. Би хоолны жор ашиглан хоол хийж сурмаар байна.



4. Эгшиг үсэг нөхөж бичээрэй.

Энэ бол с . в суулга. Миний эмээ т . раг бүрэв. Ц . гаан идээг байнга хэрэглэж байгаарай. Би луув . н идэх дуртай. Дэлгүүрээс өр . м худалдаж авлаа. Цагаан . дээг дээдлэн хүндэтгэх заншилтай.



5. Зургийг нэрлээд, өгүүлбэр зохиогоорой.

Энэ бол ....



Энэ бол ....



Энэ бол ....



## Бүлэг VII. АМЬТАД

### Зурагт толь




Бар




Сарьсан  
багваахай




Үнэг



Баавгай



Зурам



Буга




Галуу



Хэрээ



Болжмор



Аргал



Арслан




Ноос




Адууны дэл



Сүүл




Мөөрөх



Майлах




Буйлах



Янцгаах



Могой



Зээр

## ДАСГАЛ 1



1. Эхийг уншаарай.

### Таван хошуу мал

Тэмээ, үхэр, адуу, хонь, ямааг таван хошуу мал гэдэг. Тэмээ, адуу, үхрийг бод мал, хонь ямааг бог мал гэнэ. Манай орон малаар баян. Малын сүү, арьс, ноос, ноолуур, хөөвөр, дэл, сүүлийг хэрэглэдэг. Малын аргал, хомоолыг түлээ болгоно.



2. Таван хошуу мал ямар дуу, чимээ гаргадаг бол?. Ярилцаарай.

Ямар малын дуу болохыг таагаарай.



3. Асуултад хариулаарай.

- А. Үхэр бод мал уу, бог мал уу?
- Б. Ямаа ямар мал вэ?
- В. Таван хошуу малын юу, юуг хэрэглэдэг вэ?
- Г. Ямааны ноолуураар юу хийдэг вэ?
- Д. Малын арьсаар юу хийдэг вэ?
- Е. Аргал, хомоолын ач тусыг ярилцаарай.



4. Өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.


Тэмээ буйлна.	..... мөөрнө.	..... янцгаадаг.
Хонь .....	Ямаа .....	Унага .....
Ишиг .....	Ботго .....	Тугал .....
хурга .....		



5. Эхийг цэвэр сайхан бичээрэй.

Малын арьсаар ....., ....., ....., ..... хийдэг. ....ны ноолуур, ..... ны ноосоор янз бүрийн хувцас хийдэг. Ямааны ноолуураар хийсэн хувцас үнэтэй.




 1. Харилцан яриаг дүрээр уншаарай.


**Амьтад яаж унтдаг вэ?**

- Туулай чи яаж унтдаг вэ?
  - Би хэвтэж унтдаг.
- Тэгвэл болжмор чи яаж унтдаг вэ?
  - Сууж байгаад л унтдаг.
- Харин нохой чи яаж унтдаг вэ?
  - Би хэвтэж байгаад унтдаг.
- Би л бусдаас илүү тавтай унтдаг, бүхнээс сайхан амардаг юм байна.
- Чи тэгэхлээр яаж унтдаг вэ?
  - Юмнаас зүүгдэж унтдаг юм гэж сарьсан багваахай хэлэв.




 2. Асуултад хариулаарай.

- Ямар амьтад хэвтэж унтдаг вэ?
- Ямар амьтан өөрийгөө сайхан амардаг гэсэн бэ?
- Амьтдын унтдаг байдлыг хэлнэ үү.
- Чиний мэддэг амьтад яаж унтдаг вэ?

 3. Холбоо үг үүсгэн уншаарай.

туулай	—	үүр	туулай	—	хэвтэр
нохой	—	үүр	нохой	—	хэвтэр
үхэр	—	зэл	үхэр	—	хэвтэр

 4. Яаж?, яана? гэсэн асуултад тохирох үгийг нөхөж, өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

- Туулай үүрэндээ бөжинтэйгөө яана?
- Нохойн үүрэнд олон гөлөг яаж? байна.
- Үхрүүд зэлэн дээр яана?
- Сарьсан багваахай унтахдаа модноос яадаг?

Яав?, яаж байна?, яадаг?, яана? гэсэн асуултад хариулагдах үгс нь үйл хөдлөлийг зааж нэрлэсэн үгс байна.

Жишээ нь: хооллов, хооллож байна, хооллодог, хооллоно

## ДАСГАЛ 3



1. Эхийг уншаад, дэвтэртээ сайхан бичээрэй.

### Бүргэд

Бүргэд том биетэй, махчин шувуу. Тэд маш өндөрт нисэж, амьтдыг мөрөөр нь олдог. Уулын орой, ой, хээр талд амьдардаг. Манай ард түмэн бүргэдийг их дээдэлдэг. Манай аймагт жил бүр бүргэдийн баяр болдог. Гадаад, дотоодын олон жуулчид ирж сонирхдог. Бүргэд чоно, үнэг, туулай зэрэг амьтдыг агнадаг.




2. Асуултад хариулаарай.

- А. Бүргэд ямар биетэй вэ?
- Б. Бүргэд хаана амьдардаг вэ?
- В. Бүргэдийг яагаад дээдэлдэг вэ?
- Г. Бүргэдийг хэн сонирхдог вэ?



3. Зургийг ажиглаад холбоо үг үүсгээрэй.




4. Шувуудыг нэрлээд асуух өгүүлбэр зохиогоорой. Цэгийн оронд тохирох үгийг бичээрэй.

Тогоруу ..... хөлтэй.  
Хун ..... өнгөтэй.  
Шар шувуу ..... нисдэг.  
Болжмор ..... өнгөтэй.  
Шаазгай ..... дуугардаг.  
Тоншуул ..... дуугардаг.




 1. Зургийг нэрлээрэй.




 2. Эхийг уншаарай.

**Шувууд**

Манай оронд хавар хун, галуу, нугас, ангир, тогоруу зэрэг шувууд дулаан орноос нисэж ирдэг. Усны сайхан шувууд манай оронд ирж өндөглөдөг. Намар болохоор дулаан оронд буцдаг. Эдгээр шувуудыг нүүдлийн шувууд гэдэг. Хэрээ, болжмор, хөхөө зэрэг шувууд өвөлждөг. Эдгээр шувууд өвөлждөг шувууд юм.

 3. Бүлэглэн бичээрэй.

	Нүүдлийн шувууд	Өвөлждөг шувууд
Эхэд байгаа		
Чиний мэдэх		

 4. Зургийн үйл явдалд тохируулан өгүүлбэр зохиогоорой.



1. \_\_\_\_\_
2. \_\_\_\_\_
3. \_\_\_\_\_
4. \_\_\_\_\_

## ДАСГАЛ 5

1. Үлгэрийн дүрээр төлөөлөн уншаарай.

### Заан сармагчин хоёр

Сармагчин, заан хоёр сайн найзууд байв. Нэг удаа заан “Над шиг хүчтэй амьтан хаана ч байхгүй. Би хамгийн хүчтэй нь” гэж хэлэв. Гэтэл сармагчин “Над шиг өндөр үсэрдэг амьтан хаана ч байхгүй” гэжээ.



Тэгээд бяцхан болжморыг дуудаж, хэн нь илүү эрдэм чадалтайг хэлж өг гэж гэнэ. Болжмор “Та хоёр голын цаана байгаа модноос жимс түүгээд ир. Тэгэхээр чинь хэлж өгье” гэв.

Голын хөвөөнд ирлээ. Сармагчин их усыг хараад “Хэрхэн гатлах билээ” гэж санаа зовон хэлэхэд заан “Би чамд тусалъя” гээд сармагчинг нуруундаа суулгаад, уснаас гарав.




Модны дэргэд ирэв. Заан модны оройд байгаа жимсийг хараад авч чадахгүй байв. “Заан ах аа! Би модон дээр гарч жимс буулгая. Та түүчих” гэж сармагчин хэлэв.

2. Асуултад хариулаарай

- Ямар амьтдын тухай үлгэр вэ?
- Тэд хаана очсон бэ?
- Болжмор юу гэж хэлэв?
- Заан сармагчинд яаж туслав?
- Сармагчин заанд яаж туслав?
- Амьтдын тухай өөр ямар үлгэр мэдэх вэ?

3. Тусч найзынхаа тухай дөрвөн өгүүлбэрт багтаан бичээрэй.

сайн, эелдэг, зоригтой, сэргэлэн, чадалтай, хичээнгүй, зөөлөн, тусархуу

 1. Шүлгийг уран тод уншаарай.


Даам

Хэрэм бамбарууш хоёр  
Хэзээний сайн найзууд  
Хамт дэлгүүр орж  
Хайсан тоглоомоо олжээ.


Алиа сэргэлэн найзууд  
Авсан даамаараа тоглов.  
Хичээнгүй бодож суусаар  
Хэрсүү бамбарууш хожжээ.

Дэлгүүрт байсан тоглоомууд  
Дэггүй хэрэмд бодогдоод.  
Бодож байсан нүүдлээ  
Буруу хийгээд хожигдлоо.

Р. Баярцогт

 2. Асуултад хариулаарай.

- А. Ямар амьтад найз байсан бэ?
- Б. Тэд хаана очсон бэ?
- В. Ямар тоглоом худалдаж авсан бэ?
- Г. Аль амьтан хожсон бэ?
- Д. Хэрэм яагаад хожигдсон бэ?


 3. Тайлбарлан ярилцаарай.




Хэрсүү  
бамбарууш гэж  
нэрлэсэн учир  
юу вэ?



Дэггүй хэрэм  
гэж нэрлэсэн  
учир юу вэ?

 4. Шүлгийн аль нэг бадгийг дуурайн дөрвөн мөрт бичээрэй.



Дуурайн бичихдээ:


- Толгой холбон
- Агуулгыг дуурайн
- Сүүл холбон
- Мөр бүрийн үгийн тоо ижил

_____	_____	_____
_____	_____	_____
_____	_____	_____
_____	_____	_____

## ДАСГАЛ 7



### 1. Амьтдыг нэрлээрэй.




.....




.....



.....



.....



.....



.....



.....



.....



.....



### 2. Эхийг уншаад дэвтэртээ хичээнгүй сайхан бичээрэй.

Тэмээ, адуу, үхэр, хонь, ямаа, нохой, муур, тахиа бол гэрийн тэжээмэл амьтад. Гэрийн тэжээмэл амьтдыг гэртээ тэжээдэг. Арслан, бар, чоно, үнэг, буга нь зэрлэг амьтад, туулай, тарвага, зээр нь зэрлэг амьтад. Тэд ууланд, ойд, хээр талд амьдардаг юм.




### 3. Бүлэглэн бичээрэй.

	Тал хээрт амьдардаг амьтад	Ойд амьдардаг амьтад	Гэрийн тэжээмэл амьтад
Эхэд байгаа			
Чиний мэдэх			

## Бүлэг VIII. БАЙГАЛЬ ДЭЛХИЙ

### Зурагт толь



Тагтаа



Шар шувуу



Хараацай




Ангаахай



Мөчир



Үүр



Талхны үртэс




Уяа




Нүүх




Буух



Нисэх



Тонших



Солонго



Үүл



Аянга



Бороо

## ДАСГАЛ 1



1. Харилцан яриаг уншаарай.



**Болд:** Хоёулаа гадаа гарах уу?

**Баатар:** Гадаа бороо орж байна.

**Болд:** Бороо орох сайхан шүү дээ.

Салхи л битгий гараасай.

**Баатар:** Тийм дээ. Бороо ороод,  
солонго татах нь бүр ч гоё

**Болд:** Найз аа! хараарай. Солонго татаж байна.

**Баатар:** Тийм байна.

**Болд:** Солонго өвөл татдаг болов уу?

**Баатар:** Үгүй дээ. Зуны улиралд, бороо  
орсны дараа солонго татдаг.



2. Болдын найздаа уншиж өгсөн шүлгийг цээжлээрэй.

### Солонго

Намираа борооны дараа  
Нар таатай ээлээ  
Өнгөрсөн борооны наагуур  
Өнгийн солонго татлаа  
Тэр солонгыг барих гэж  
Тэнхээгээрээ бид хурдлав  
Цагираг солонго харин  
Цаашаа зугтан одов.  
Байгалийн сайхан солонгыг  
Барьж болдоггүйг мэдэв

*Р.Ядмаа*



3. Дараах үгсийг зөв уншиж, холбоо үг бүтээн бичээрэй.

бороо

цас

салхи

солонго

дуугарах

аянга

орох

татах

салхилах



4. Холбоо үгсийг оролцуулан асуух өгүүлбэр зохиож, уншиж өгөөрэй.




?





?






?

1. Зургийг нэрлээрэй.



2. Холбоо үгсийг уншаарай.

бараан

шиврээ

бөөн цагаан

үүл

ширүүн

бороо

сэмжин

аадар

цас

орох

шуурга

дэгдэх

хайлах

намдах

3. Эхийг уншаарай.

Тэнгэр бүрхэв. Салхи салхилав. Цас орлоо. Цасан шуурга дэгдэв. Шуурга намдав. Найзтайгаа цасаар тоглов.

4. Асуултын дагуу ярилцаарай.

Эхлээд Тэнгэр яасан бэ?

Дараа нь Салхи яасан бэ? Юу орсон бэ? Шуурга яасан бэ?

Эцэст нь Найзууд юугаар тоглосон бэ?

## ДАСГАЛ 3



### 1. Харилцан яриаг уншаарай.

Төгөлдөр: -Өнөөдөр цаг агаар ямар байна вэ?

Аманжол: -Өнөөдөр цаг агаар хүйтэн, цас орж байна.

Төгөлдөр: -Танай нутгаар цас их ордог уу?

Аманжол: -Тийм ээ. Өвөлдөө цас их ордог шүү.


Төгөлдөр: -Цаг агаарын мэдээгээр танай нутагт хэдэн хэм байна вэ?

Аманжол: -Цаг агаарын мэдээгээр 32 хэм хүйтэн, цас орно гэж зарласан. Чи өөрийнхөө нутгийн цаг агаарын мэдээг сонссон уу?

Төгөлдөр: -Би цаг агаарын мэдээ сонслоо. Манай нутагт цаг агаарын мэдээгээр 15 хэм хүйтэн, зөөлөн салхитай гэж байна.



### 2. Өгүүлбэр зохиож бичээрэй.



Хүчтэй цасан шуурга хоёр өдөр үргэлжилнэ.



### 3. Оньсого таагаарай.

Өндрөөс  
Өөх унана

Тэр юу вэ?

Шинэхэн дээрээ  
Хөвөн шиг  
Хуучрахаараа  
Төмөр шиг

Тэр юу вэ?

Хөмөрсөн арганд  
Хөнгөн цамц өмсгөнө

Тэр юу вэ?



1. Шүлгийг уран тод уншаарай. Цээжлээрэй.



**Намар**

Намрын шар нар над дээр, чам дээр тусна  
 Найган найгах улиралд нь бид бас найгана  
 Буга хандгай урамдаж уул усыг баясгахад  
 Үхэр шар мөргөлдөн малчин хүнийг зугаацуулна.

**Өвөл**

Алсын салхи жихүүн амьсгалаар тас няс хийхэд  
 Алтан дэлхийн уул тал мөнгөн хуягийг өмсөнө  
 Өвлийн шөнө тэнгэрийн одод оч мэт гялалзахад  
 Уудам талд жинчин хүний дуулах яруу



**Зун**

Цагийн сайхан зуны эхэнд  
 Газрын сайхан хангайн нуруунд  
 Хөхөө шувуу урьхнаар донгодох үес  
 Энэхүү дэлхий юутай сайхан тааламжтай

**Хавар**

Мөнх тэнгэрийн дор мянга мянган хавар  
 Монголын сайхан оронд жил жил дэлгэр  
 Энх улирал ханхлахад хүний сэтгэл тэнэгэр  
 Өвсний соёо ногоороход морь мал ханагар  
 Д.Нацагдорж



2. Дөрвөн улирлын тухайн шүлэгт юу юу дүрслэгдэж байгааг тоочин бичээрэй.

Four empty boxes for writing, each with a letter in a circle above it:

- Ө
- Х
- З
- Н

## ДАСГАЛ 5



1. Эхийг ойлгон уншаарай.



Манай орны ой хөвчид 140 орчим зүйлийн мод ургаж байна. Тус орны ойн талбай нь Афганистан, Австри, Англи, Пакистан, Португали, Швейцари зэрэг зургаан орны нийт ойг нийлүүлсэнтэй тэнцэх юм.

Ой бол амьтан, ургамал, бичил биетний амьдрах орон гэр юм. Ой мод нь агаарыг цэвэршүүлдэг, уур амьсгалыг зөөлрүүлдэг, усны урсацыг зохицуулдаг, хөрсийг элгэдэл, эвдрэлээс хамгаалдаг.

### Манай орны ой



2. Асуултад хариулаарай.

- А. Манай оронд хэдэн төрлийн мод ургадаг вэ?
- Б. Монгол орны нутаг ямар ямар улсын нутагтай тэнцэх вэ?
- В. Ой мод нь ямар ашиг тустай вэ?



3. Холбоо үгийг уншаарай.

Ой мод	Нарсан ой	Шилмүүст ой
Ой шугуй	Хусан ой	Ширэнгэн ой



4. Үгийн утгыг тайлбарлан ярилцаарай.

Үг	Миний бодлоор	Толь бичигт
Нүүрстөрөгч		
Хүчилтөрөгч		



5. Асуултын дагуу ярилцаарай.

- Мод хүчилтөрөгчийг ялгаруулснаар хүмүүс бидэнд ямар тустай вэ?

Мод нь хүчилтөрөгчийг ялгаруулдаг. Бид хүчилтөрөгчгүй амьдарч чадахгүй.



5. Нэг өгүүлбэрээр уриалж бичээрэй.

- Ой модоо хамгаалах тухай
- Мод тарих аянд нэгдэх тухай
- Ой модыг цэвэрлэх тухай

## Бүлэг IX. ХУВЦАСЛАЛТ, ХУВИЙН СОЁЛ

### Зурагт толь



Дээл



Эсгий гутал



Усны гутал



Эсгий шаахай




Үндэсний гутал



Саравчтай малгай



Алчуур



Торго



Савхин бээлий



Нарны шил



Борооны цув



Ханиад



Өвс хадах



Ногоо хураах



Хонх цохих



Урд



Хойд



Энгэр



Даарах



Зузаан

## ДАСГАЛ 1



1. Хувцасны нэрийг нэрлээрэй.



2. Хувцасны нэр дээр өнгө заасан үг нэмж, холбоо үг үүсгэж бичээрэй.



3. Холбоо үгээр асуух өгүүлбэр зохиогоорой.



4. Өвөл, зуны улиралд өмсөх хувцаснуудыг ялгаж бичээрэй.

Өвлийн хувцас	Зуны хувцас



5. Асуултад хариулаарай.

- А. Аялалд гарахдаа ямар хувцас өмсдөг вэ?
- Б. Биеийн тамирын хичээлд ямар хувцастай ордог вэ?
- В. Сургуульд явахдаа ямар хувцастай очдог вэ?
- Г. Цагаан сар, Наурызын баяраар ямар хувцас өмсдөг вэ?
- Д. Ямар, ямар мэргэжлийн дүрэмт хувцас байдаг вэ?



1. Харилцан яриаг уншаарай.



Нараа: -Сайн уу? Болороо.

Болороо: -Сайн, сайн уу Нараа.

Нараа: -Чи хичээлдээ өмсөх дүрэмт хувцсаа авсан уу?

Болороо: -Үгүй, одоо авна.

Нараа: -Манай сургуулийн охидууд хар юбка, цагаан цамц өмсөнө. Харин танай сургууль ямар хувцас өмсөх вэ?

Болороо: -Манай сургуулийн охид цэнхэр цамц, хар хөх юбка өмсдөг. Заримдаа хүүхдүүд янз бүрийн хувцастай ирдэг.

Нараа: -Тийм үү. Сурагч хүүхэд дүрэмт хувцас өмсөх нь зөв гэж ээж минь хэлдэг. Бас цэвэрхэн хувцаслаж явах хэрэгтэй гэдэг.

Болороо: -За, би явъя даа

Нараа: -Баяртай.

Болороо: -Баяртай.



2. Асуултад хариулж бичээрэй.

А. Нараагийн сургуулийн охид ямар хувцас өмсдөг вэ?

Б. Болороогийн сургуулийн охид ямар хувцас өмсдөг вэ?

В. Нараагийн ээж юу гэж хэлсэн бэ?

Г. Танай сургуулийн хүүхдүүд ямар дүрэмт хувцас өмсдөг вэ?

Д. Нараагийн цамц нь ямар өнгөтэй байдаг вэ?

Е. Болороогийн цамц нь ямар өнгөтэй байна вэ?



3. Харилцан ярианаас өнгө заасан үгийг ялгаж бичээрэй.



4. Холбоо үгсийг дөрвөн улирлаар бүлэглэж бичээрэй.

ноосон малгай, ноосон цамц, эсгий гутал, булган малгай, саравчтай малгай, ноолууран ороолт, савхин бээлий, нимгэн оймс, хүүхдийн дотуур хувцас, өвлийн гутал, зуны туфли, жинсэн өмд, нарны шил, нэхий дээл, үндэсний дээл, үнэгэн малгай, булган дээл, даавуун оймс, буриад гутал, гоёлын даашинз, борооны цув, дүрэмт хувцас

өвөл

хавар

намар

зун

### ДАСГАЛ 3



1. Зургийн дагуу ярилцаарай.



2. Зургийг ажиглаад асуултад хариулаарай.

- А. Ямар улиралд өвс хаддаг вэ?
- Б. Хүнсний ногоог хэзээ хураадаг вэ?
- В. Хичээл хэдийд эхэлдэг вэ?
- Г. Хүнсний ногооны ач тус юу вэ?



3. Хүүхдүүд ямар хувцастай байгааг яриарай. Өгүүлбэр болгож бичээрэй.



4. Зөвлөмжийг уншаарай. Зуны улиралд өмсөх хувцасны тухай зөвлөмж бичээрэй.

#### Зөвлөмж

Өвлийн улиралд цаг агаар их хүйтэрдэг. Тиймээс дулаахан хувцас өмсөх хэрэгтэй. Өвөл малгай, бээлий өмсөж, ороолт зүгээрэй. Ханиад томуу ихдэх учир даарахгүй байхад анхаараарай.

#### Зөвлөмж

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....


1. Эхийг уншаарай.

Шинэ дээл өмсөх ёс

Монголчууд хүүхдээ шинэ дээл өмсөхөөр дараах мялаалгын үг хэлдэг уламжлалтай.



Урт насалж  
Удаан жаргаарай  
Урд хормойг нь **унага даага гишгэг**  
Хойд хормойг нь хонь хурга гишгэг  
Дотоод энгэр нь тос өөх болог  
Гадаад энгэр нь гадар өөх болог  
Эзэн нь мөнх  
Эд нь **хэврэг**  
Энэ жил **торго**  
Ирэх жил **чисчүү** өмсөөрэй  
**Тооноор цухуйсан** том хүн болоорой





гэж бэлгэтэй үгээр **ерөөж**, чихэр жимсээр **мялааж**, хүүхдийг баярлуулдаг зан заншилтай юм.

2. Тодруулсан үгийг давтан уран тод уншаарай.

хэврэг	торго	ерөөх	мялаах
бат бөх	дурдан	магтах	баярлуулах

4. Бүдүүвчийг ашиглан “Зун” “сэдвээр эх зохиогоорой.




5. Үгийн сүлжээг бөглөөрэй.

Хөндлөн

1. Хүйтний эсрэг утга
2. Нөхрийн эсрэг утга
3. Өдрийн эсрэг утга

Босоо

1. Үнэний эсрэг утга
2. Нимгэний эсрэг утга
3. Намханы эсрэг утга



## ДАСГАЛ 5



1. Харилцан яриаг хосоороо уншаарай.

**Оюун:** Сайн уу?

**Хулан:** Сайн, сайн уу?

Чи яагаад малгай өмсөхгүй явж байна вэ? Өвлийн улиралд дулаахан хувцас өмсөж яваарай гэж ээж үргэлж хэлдэг. Би малгай, ороолт, бээлий заавал өмсдөг.

**Оюун:** Тийм шүү. Маргааш сургуульдаа ирэхдээ малгайгаа заавал өмсөнө. Чи өнөөдөр бүжгийн дугуйланд ирэх үү?

**Хулан:** Тийм ээ ирнэ. Өнөөдөр 14.00 цагаас урлаг зааланд хичээллэнэ. Багш дугуйланд ирэхдээ хар юбка, цагаан цамцтай ирээрэй гэсэн.

**Оюун:** Аан тийм үү. Би тэгвэл хувцасаа бэлдлээ.



2. Асуултад хариулж бичээрэй.

- А. Хулан Оюунд юу гэж хэлсэн бэ?
- Б. Хулангийн ээж юу гэж захьдаг хэлдэг вэ?
- В. Өвлийн улиралд яаж хувцаслах хэрэгтэй вэ?
- Г. Оюун ямар дугуйланд явдаг вэ?
- Д. Дугуйлан хэдэн цагаас эхэлдэг вэ?



3. Цэгийн оронд тохирох үгийг бичээрэй.

Өвлийн улиралд ..... хувцас өмсдөг. Өвөл малгай ....., ....., өмсөх хэрэгтэй. Зуны улиралд ..... зүүх хэрэгтэй. Бороо орсон үед ..... өмсөөрэй. Зун ..... өмсөх хэрэгтэй.



4. Дараах үгсийн эсрэг утгатай үгийг бичээрэй.

дулаан -

зөв -

хар -


өмсөх -

ирэх -

өвөл -



5. Зургийн дагуу гарчиг өгч, эх зохиогоорой.



## Бүлэг Х. УЛАМЖЛАЛТ ЁС ЗАНШИЛ, ТЭМДЭГЛЭЛТ БАЯР ЁСЛОЛ

### Зурагт толь



Ул боов



Хонины ууц



Хадаг



Золгох



Сур харвах



Бөх барилдах




Морь уралдах



Булаг



Зочин



Нар тусах



Яарах



Гоёх



Тохой



Цугларах



Чанах



Дайлах

## ДАСГАЛ 1



1. Шүлгийг цээжлэхдээ зургаар дүрсэлснийг ажиглаарай.  
Хэмнэлийг тохируулан уншаарай.

### Олон баяр - Миний баяр

Сургууль эрдэм рүү  
Яаран тэмүүлсэн  
Эрдмийн баяр-Миний баяр



Өвлийн өвөөгөөс  
Бэлэг авдаг  
Шинэ жилийн баяр-Миний баяр




Монголын үзэсгэлэнт  
Саран гоо ээжийн минь  
Эхчүүдийн баяр-миний баяр



Хүүхэд бидний  
Хүслэн болсон  
Хүүхдийн баяр-Миний баяр



Морь уралдаж  
Бөх барилдаж  
Сур харвадаг  
Наадам-миний баяр



Баяр бүхэн даанч сайхан  
Байнга болдоггүй нь даанч тусгүй.


Шүлэг Б.Хадбаатар

- Хүнийг нэрлэсэн үгс хэн?, юу? гэсэн асуултад хариулагддаг.
- Үйл хөдлөлийг нэрлэсэн үгс яав?, яасан? яаж байна? гэсэн асуултад хариулагддаг.



2. Шүлгээс хүнийг нэрлэсэн, үйл хөдлөлийг нэрлэсэн үгийг бүлэглэн бичээрэй.


Хүнийг нэрлэсэн үг ( 6 )	Үйл хөдлөлийг нэрлэсэн үг ( 7 )
- миний	- тэмүүлсэн

 1. Шүлгийг уншаад цээжлээрэй.


**Миний дуртай баяр**

Сурагчийн дүрэмт хувцсаа өмсөөд  
 Сурч мэдэхийн өргөө  
 Сургуульдаа яаран очсон  
 Есөн сарын нэгэн- миний дуртай баяр  
 Аав, ээжээс мэндэлсэн  
 Амттан бүхэн дүүрэн  
 Найз нөхдөө урьсан  
 Нас нэмсэн өдөр – миний дуртай баяр



 2. Шүлгээс хүн ба үйл хөдлөлийг нэрлэсэн үгийг бүлэглэн бичээрэй.

Хүнийг нэрлэсэн үг	Үйл хөдлөлийг нэрлэсэн үг

 3. Асуултад хариулж, дэвтэртээ бичээрэй.


**Шүлэг зохиоходоо:**

- толгой холбож
- агуулгыг дуурайж
- мөр бүрийн үгсийн тоог дуурайж бичнэ.

Шүлэгт хэдэн мөр байна вэ?  
 Шүлэгт ..... мөр байна.

Мөр бүрийн үгийн тоо хэд байна вэ?  
 Мөрийн үгийн тоо ..... байна.

Толгой холбосон ямар үсэг байна вэ?  
 Толгой холбосон үсэг С, ....., .....

 4. Шүлгийг дуурайн зохиож бичээрэй.



**Миний төрсөн өдөр**

_____	_____	_____
_____	_____	_____
_____	_____	_____
_____	_____	_____

### ДАСГАЛ 3



1. Уламжлалт ёс заншлыг харуулсан баярыг олж ярилцаарай.



2. Асуултад хариулаарай.



Цагаан сарын баяр

- ..... ямар улиралд болдог вэ?
- ..... хэдэн сард болдог вэ?
- ..... ямар баярын дараа болдог вэ?
- ..... аль түмний баяр вэ?

Цагаан сарын баяр хоёрдугаар сард болдог.

Наурызын баяр гуравдугаар сард болдог.



Наурызын баяр

- ..... ямар улиралд болдог вэ?
- ..... хэдэн сард болдог вэ?
- ..... ямар баярын дараа болдог вэ?
- ..... аль түмний баяр вэ?



3. Зүйр цэцэн үгийг цээжлээрэй, цэвэр бичээрэй.

Буурлаас үг сонс  
Болсноос ам хүрт

Унасан газар угаасан ус  
Аав ээж шиг ачтай

Айл аймаг эвтэй нь сайхан  
Ахан дүүс найртай нь сайхан

Аавын сургаал элт  
Ээжийн сургаал эрдэм  
Ахын сургаал ач  
Эгчийн сургаал элбэрэл

1. Аль нэг эхийг сонгон чангаар дуудаж уншаарай.  
Ширээнийхээ найзын уншихыг анхааралтай сонсоорой.



**Цагаан сарын баяр**

“Цагаан сар” гэж хаврын тэргүүн сарын баярыг хэлдэг. Энэ өдөр ул боов, ааруулаар таваг засаж, хонины ууц тавин ширээ засна. Үндэсний хувцсаараа гоёдог. Цагаан сарын баяраар хамгийн эхлээд ахмад хүмүүст очиж золгодог. Хадаг барин, ахмад хүний тохойг өргөн “Та амархан сайн байна уу?”, “Сайхан шинэлж байна уу?” гэж мэндэлдэг. Ирсэн зочдыг халуун цай, бууз, амттанаар дайлдаг.

**Наурызын баяр**

Наурызын баяр гуравдугаар сарын хорин хоёронд болдог. Энэ өдөр хүмүүс үндэсний хувцсаа өмсдөг. Наурыз көже хийдэг. Наурыз көжед мах, казы, карта чанаж шөлөндөө долоон төрлийн хүнс хийж, ширээ засаж, бие биенээ бэлэг дэмбэрлийн үгээр ерөөдөг. Үндэсний тоглоом тоглох, шинээр мод тарих, булаг, рашаан, орчноо цэвэрлэх ажил хийдэг.



4. Цэгийн оронд уламжлалт баярын нэрийг хэлж бичээрэй.



..... ямар хувцас өмсдөг вэ?  
..... ширээг яаж засдаг вэ?  
..... ямар идээгээр дайлдаг вэ?



..... ямар хувцас өмсдөг вэ?  
..... ширээг яаж засдаг вэ?  
..... ямар идээгээр дайлдаг вэ?

5. Уламжлалт баярын онцлогийг тоочин бичээрэй.

Цагаан сар	Наурызын баяр

## ДАСГАЛ 5



1. Шүлгийг уран, тод уншаарай.



### Мэдэж авлаа

Цагаан сарын шинийн нэгний өглөө  
Цайгаа чанаж, гоёлоо өмсөөд  
Тооноор нар тусахын үед  
Томчууд, хүүхдүүд өвөөгийн цуглаад  
Гэр дүүрэн хүмүүс хоорондоо  
Гар зөрүүлэн бүгдээр золгов.

Ажаад байсан чинь  
Аав ээжтэй золгосонгүй  
Ах бэргэн эгчтэй золгосонгүй  
Авгай нөхөр хоорондоо золгодоггүй  
Ардын ёс байдгийг мэдлээ.

*Д.Санжжав*



2. Асуултын дагуу ярилцаарай.



Өвөөгийн хэн, хэн ирсэн бэ?  
Хэзээ гоёлоо өмсдөг вэ?  
Өвөөгийн хэзээ цугладаг вэ?  
Яагаад аав, ээжтэй золгоогүй вэ?



3. Тохирох үгийг нөхөж бичээрэй.

..... чанана.	..... өмсөнө
..... тусна	..... цуглана
..... мэдлээ.	..... золгоно



4. Өгүүлбэрийг гүйцээн бичээрэй.

*Жишээ: Аав өвөөтэй золгоно. Харин аав ээжтэй золгохгүй.*

Ах өвөөтэй золгоно. Харин .....

Ээж эмээтэй золгоно. Харин .....


Өвөөтэй хүн бүр золгоно. Харин .....

Бэргэн эгч аавтай золгоно. Харин .....

Харин би хүн бүрийг хүндлэн .....

# БАТАТГАЛ

## ДАСГАЛ 1


 1. Эхийг уншиж ойлгоорой.

### БУУЗ

Хүүхдийн цэцэрлэг дээр ийм явдал болов. Хүүхдүүд өдрийнхөө хоолыг идэх гэж байв. Тэд гараа угаагаад ширээ тойрон суув. Гэтэл гал тогооны газраас нэг бууз бусдаасаа түрүүлэн хүүхдүүдийн өмнө ирж ингэж асууж гэнэ.


- За хүүхдүүд ээ! Би хаанаас төрж, хаана бойжоод ямар замаар та нарын өмнө хүрч ирээд байна вэ? Хэн зөв хариулсны чинь өмнө хэд л бол хэд болж үржинэ гэжээ. Тэгтэл нэг бяцхан охин,
- Бөндгөр хөөрхөн бууз минь чи бөндөгнөн өнхөрч хүрч ирсэн гэв.

*Ц.Уланбаяр*


 2. Асуултын дагуу ярилцаарай.

- Хаана болсон явдал вэ?
- Хүүхдүүд яах гэж ширээ тойрч суусан бэ?
- Ширээ тойрон сууж байтал юу болов?
- Бууз юу гэж хэлсэн бэ?
- Хэн, юу гэж хариулсан бэ?
- Бууз ямар төрлийн хоол вэ?




 3. Буузны хэлсэн үгийг ялган бичээрэй.

.....  
.....

 4. Доорх хүснэгтийн дагуу эхээс түүж бичээрэй.

Хэн?	Юу?	Ямар?	Хичнээн?	Хэзээ?	Яав?

 5. Үгсийг зөв байрлуулан өгүүлбэр бүтээн уншиж, хичээнгүй сайхан бичээрэй.

ээж

өгөв

Миний

хийж

амттай

бууз

## ДАСГАЛ 2



1. Харилцан яриаг төлөөлөн уншаарай.

### Гөлөг зулзага хоёр



**Зулзага:** Дахиад нэг оньсого хэлээрэй. Дэлхийн бүх оньсогыг би мэднэ.

**Гөлөг:** Гуруй гуруй биетэй гучин гурван нуруутай Шарга шарга биетэй шар шувуун нүдтэй тэр юу вэ?

**Зулзага:** Яасан амархан оньсого вэ? Яг л оготно байна мөн үү?

**Гөлөг:** Гуруй гуруй биетэй гучин гурван нуруутай Хүүе, яана аа Зулзага минь. Хэзээ оготно том нүдтэй байсан юм бэ?

**Зулзага:** Аа мэдлээ, мэдлээ. Аймар урт могой байна тийм үү.

**Гөлөг:** Би ямар гоё оньсого хэлэв ээ. Бодоод бодоод чи таахгүй юм байна.

**Зулзага:** Тэгвэл наадах чинь тэмээ юм уу? Эсвэл эрвээхий л байна. Тэр хоёрыг би сайн таньдаг юм.

**Гөлөг:** Гуруй гуруй биетэй гучин гурван нуруутай Шарга шарга биетэй шар шувуун нүдтэй зулзага чи л байна шүү дээ.

**Зулзага:** За, чамайг даа! Заавал гүйцэж маажна даа гээд ухасхийв.

**Гөлөг:** Мэддэгт мэргэн цоохор мэддэггүйд ..... (юу? гэдэг билээ) энэ шүү дээ.



2. Зургийн дагуу эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг ярилцаарай.



3. Чиний бодлоор энэ хоёрын үйл явдал яаж төгсвөл тааламжтай вэ? төгсгөл хэсгийг бичээрэй.

Handwriting practice lines consisting of four columns of horizontal lines (top solid, middle dashed, bottom solid) and vertical lines separating the columns.



1. Эхийг уншаарай.

**Хэрэмний аялсан тэмдэглэл**

Зуны амралт болж хорилдой аялал хийж зуны халуун өдрүүдийг ардаа хийхээр шийджээ. Тэрээр ойг гатлан нэг горхины хөвөөнд очиж ус авахаар яваа цагаан бөжинтэй таарав.

Цагаан бөжин модон хувингаа усан дотор тавиад хөдөлгөж чадахгүй байгааг хараад хорилдой яаран түүнд тусаллаа.

-Чамд баярлалаа. Чи тун сайн юм гэж цагаан бөжин сэтгэл догдлон хэлээд хорилдойг гэртээ урьж хамт тоглов. Хорилдой цагаан бөжингийн очиход цагаан бөжингийн ээж нь түүнийг дотносон хүлээн авчээ.

Цагаан туулайн ээж хорилдойн юмны учрыг ойлгодог, сайхан сэтгэлтэйг мэдээд цагаан бөжин, хорилдой хоёрыг хамт аялуулж, тэр хоёр их юм сурч мэдэж авчээ.

Үгийн утгын тайлбар:

Үг	Миний бодлоор	Толь бичигт



2. Зургийг ажиглаад, эхийн үйл явдлыг ярилцаарай.



Эхлээд яасан бэ?

Дараа нь юу болсон бэ?

Эцэст нь юу болов?



3. Хорилдойн тухай цагаан туулайн ээжийн сэтгэгдлийг бичээрэй.



4. Чамд тусалсан тусч үйлийн тухай тэмдэглэл бичээрэй.

Эхлээд яасан бэ?

Дараа нь юу болсон бэ?

Эцэст нь юу болсон бэ?

**Санамж:**

- Бусдын бичсэн тэмдэглэл унших
- Дуурайж бичих
- Бичсэн зүйлийнхээ алдааг хянах
- Эцэслэн бичих

## ДАСГАЛ 4



1. Шүлгийг цээжлээрэй.



### ГОЁ СУРГУУЛЬ

Сурч мэдэхийн өргөө  
Сургууль, анги минь гоё  
Сууж хичээллэхэд түшигтэй  
Сандал, ширээ минь гоё  
Сайхан бичиг дурайх  
Самбар, шохой нь гоё  
Сурсан эрдмээрээ бахархах  
Сурагч багачууд нь гоё  
Бяцхан шавь нараа угтах  
Багш, ажилтан минь гоё  
Энэ бүхэн бидний  
Эрдэм түгээсэн гоё сургууль минь

Ц.Баясгалан




2. Эхийг уншаарай.

### БАГШДАА БАЯРЛАЛАА


Бид гуравдугаар ангийн сурагчид. Энэ жил монгол хэлний хичээлээр уншсанаа ярьж, тайлбарлаж, мөн дүрд тоглож сурсан. Манай анги хамгийн олон шүлэг цээжилсэн анги боллоо. Эрдэмд шамдан сургасан багшдаа баярлалаа.



3. Уриалгыг бусдад уншиж өгөөрэй.



4. Эсрэг ба ойролцоо утгатай үгээр холбоо үг бүтээгээрэй.



# МОНГОЛ ХЭЛ III ГАРЫН АВЛАГА

Хос хэлний сургалттай ерөнхий боловсролын  
сургуулийн 3 дугаар ангид судална.

Зохиогчийн баг

Ахлагч:

А.Еркегүл

Гишүүд:

Ц.Баясгалан

М.Харшыга

Д.Рая

Редактор:

Д.Эрдэнэсан

К.Ёлка

Зураач:

Н.Буян

Хэвлэлийн эх бэлтгэгч:

С.Болд

Формат: 84x108/16

Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас. 80гр/м<sup>2</sup>

Хэвлэлийн хуудас: 10х.х

Хэвлэлийн эхийг “Содпресс” ХХК-д бэлтгэж,  
“Содпресс” ХХК-д 3070 хувь хэвлэв.

ISBN 991990042-7



9 789919 900427

